

2022 ОНЫ ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- Глобал хагас дамжуулагчийн хямралыг боломж болгоё
- Сэргээгдэх эрчим хүчний салбарын ирээдүй юуг зөгнөнө вэ?
- Бондын зах зээл дэх боломжийг бүү алд
- Хөрөнгийн шинэ соёл хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
- Хөрөнгө оруулагчаас банкны эзэн болоход 3 сар үлдлээ
- Хувьцааны зах зээлд шинэ давалгаа үүслээ

Golomt Capital®

III





АГУУЛГА

- ДЭЛХИЙН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-2021 ОН
- МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-2021

2022 ОНЫ ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- ГЛОБАЛ ХАГАС ДАМЖУУЛАГЧИЙН ХЯМРАЛЫГ БОЛОМЖ БОЛГОЁ
- СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ИРЭЭДҮЙ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТУУД
ДЭЛХИЙД ЦАХИУР ХАГАЛСАН
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-2021 ОН

2022 ОНЫ ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БОЛОМЖИЙГ БҮҮ АЛД
- ХӨРӨНГИЙН ШИНЭ СОЁЛ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС
- ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ ДАВАЛГАА ҮҮСЛЭЭ
- ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС БАНКНЫ ЭЗЭН БОЛОХОД 3 САР ҮЛДЛЭЭ

БИД ТАНД ЮУ ӨГЧ ЧАДАХ ВЭ?

- БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- АРИЛЖАА, СУДАЛГАА
- АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ
- GSC АКАДЕМИ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт Голомт Капитал ҮЦК ХХК-ийн харилцагч, хөрөнгө оруулагч танаа



2021 онд дэлхий дахинд төдийгүй Монгол Улсын нийгэм эдийн засаг, хөрөнгийн зах зээл онцлох үйл явдлаар өрнүүн байв.

Улс орнуудын засгийн газар болон төв банкнуудын зүгээс ковидын үеийн эдийн засгийг сэргээх, дэмжих зорилгоор бизнес эрхлэгчид болон иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, бондын худалдан авалтыг нэмэгдүүлэх, бодлогын хүүг бууруулах зэрэг мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд 2021 онд дэлхийн эдийн засаг 6.6 хувийн өсөлтийн төлөвтэй, хөрөнгийн зах зээл 12 хувийн өсөлттэй байлаа.

Тэр дундаа Монголын хөрөнгийн биржийн нийт үнэлгээ 101 хувиар өссөн гайхалтай жил тохиолоо. Харин 2022 оны 2 сард ОХУ болон Украины хооронд хурцадмал байдал үүсэж, дайн дэгдсэн нь дэлхийн эдийн засгийг донсолгож, хөрөнгийн зах зээлд хүчтэй савлагааг авчрав.

Энэхүү дайны нөхцөл байдал нь 2018-2019 онд үргэлжилсэн БНХАУ, АНУ-ын гадаад худалдааны дайнтай дүйцэхүйц эрсдэлийг дагуулж, дэлхийн томоохон биржүүдийн үнэлгээ өндөр уналтыг үзүүлээд байна. Харин найдвартай хөрөнгө оруулалт гэгддэг алтны ханш 6.26 хувиар өслөө.

Хөрөнгийн зах зээлийн аливаа уналт эсхүл өсөлтийн чиг хандлага нь байнга үргэлжилдэггүй ба зах зээлийн энэхүү өндөр уналт нь эсрэгээрээ өндөр өгөөж хүртэх боломжийг олгож байна.

Цар тахалгүй, инфляц өсөөгүй, дайн дэгдээгүй энх цагт хөрөнгө оруулагчид индекс дагасан буюу идэвхгүй төрлийн хөрөнгө оруулалтаас өгөөж хүртдэг байв. Харин эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал тодорхойгүй байгаа энэ цагт хөрөнгө оруулалтын багцаа

хамгаалах, эрсдэл өгөөжийг тэнцвэржүүлэх, төрөлжүүлэх зорилготой идэвхтэй хөрөнгө оруулалт хийх нь чухал юм.

Тиймээс Голомт Капитал ҮЦК ХХК-ийн зүгээс зах зээлийн судалгаа шинжилгээ, мэдээ мэдээллийг харилцагчдадаа цаг алдалгүй хүргэхийн төлөө ямагт хичээнгүйлэн ажиллаж байна.

Мөн бид дотоодын инфляц 14.7 хувьд хүрсэн энэ цагт харилцагчдадаа төгрөгийн 14-16 хувийн тогтмол өгөөж хүртэх боломжтой бондын бүтээгдэхүүн, гадаад валютын бонд зэргийг дэлхийн болон дотоодын зах зээлээс санал болгосоор байна.

Түүнчлэн 2022 онд хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн том хүлээлтийг үүсгээд буй Монголын арилжааны ТОП-5 банкны IPO хийгдэх хугацаа ойртож байна.

Тиймээс Голомт Капитал ҮЦК ХХК нь харилцагчдадаа ухаалаг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад нь туслах, хөрөнгө оруулалтын багцаа удирдахад нь дэмжлэг үзүүлэх, өндөр өгөөж хүртэх боломжтой санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох зэргээр хамтдаа хөгжих эрхэм зорилгыг өвөртлөн ажиллаж байна.

Хүндэтгэсэн:

Гүйцэтгэх захирал



С.Ган-Эрдэнэ

БИДНИЙ ТУХАЙ

Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд шинэ соёлыг түгээхээр зорин ажиллаж буй Голомт Капитал ҮЦК ХХК нь 2012 онд Голомт банкны 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд андеррайтер, брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг гадаад дотоодын харилцагч, түнш, хамтран ажиллагч харилцагч байгууллагууддаа хүргэж ирсэн.

Голомт Капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд хурд нэмсэн анхдагч олон алхмуудыг хийж ирсэн бөгөөд Монголын анхны онлайн арилжааны систем, дэлхийд алдартай Interactive Brokers зэрэг үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагч тив дэлхийн хаана ч байсан хүссэн цагтаа (24/7) гадаад, дотоодын хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцож, хувьцаа, бонд, үнэт метал зэрэг бүтээгдэхүүнээс сонголтоо хийх боломжтой болсон юм.

Мөн бид ухаалаг хөрөнө оруулагчдыг бэлтгэх зорилгоор GCC академийг үүсгэн байгуулсан бөгөөд хөрөнгийн зах зээлийн талаарх шат шатны сургалтыг тогтмол зохион байгуулахаас гадна дэлхийн эдийн засаг, хөрөнгийн зах зээл, онцлох компани, хувьцааны талаарх өдөр тутмын мэдээ мэдээлэл болон долоо хоног, улирал, жилийн тайлан судалгааг хүргэн ажиллаж байна.

Бид хувийн болон төрийн эзэмшлийн компани, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт татах, санхүүжилт босгох, хэлэлцээр хийх зэрэг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэн, хөрөнгийн зах зээлд гарахад нь зуучлан ажиллаж байгаа бөгөөд дараах салбаруудад тэргүүлэгч байр суурьтай байна.

Үүнд:

- Брокерийн үйлчилгээ
- Дилерийн үйлчилгээ
- Андеррайтерийн үйлчилгээ
- Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ
- Гадаадын үнэт цаасны зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа
- Мөнгөн хөрөнгийн номинал дансны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг Санхүүгийн Зохицуулах Хорооноос авч 2012 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

Бид харилцагчдынхаа эрх ашгийг ямагт дээдлэн Монголын үнэт цаасны зах зээлийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, зах зээлд тэргүүлэгч хөрөнгө оруулалт, брокерийн компани болохын төлөө идэвхтэй үйл ажиллагаа явуулах болно.

КОМПАНИЙН АЛСЫН ХАРАА



Бидний уриа
Боломжийг нээнэ



Бидний алсын хараа
Хөрөнгө оруулалтын шинэ соёлыг бүтээнэ



Бидний эрхэм зорилго
Хөрөнгийн хуваарилалтаар баялгийг бүтээнэ



Бидний стратеги
Гүн харах

ДЭЛХИЙН БОЛОН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ 2021 ОН

Хүн төрөлхтөн 2021 онд коронавирусын эсрэг хэд хэдэн төрлийн вакциныг амжилттай бүтээснээр дэлхийн өнцөг булан бүрт вакцинжуулалт эрчимжиж, тодорхой үр дүнд хүрч эхлэв.


Гэвч коронавирусын шинэ хувилбарууд бүртгэгдэж эхэлсэн нь дэлхийн хэмжээнд бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт хомсдох, ачаа тээвэр саатах, үнэ өсөх, эдийн засгийн сэргэлт удаашрах зэрэг сөрөг үр дагаврыг дагуулсан юм.

2021 онд дэлхийн хэмжээнд цар тахлаар 279 сая хүн өвчилж, 5.4 сая иргэн нас барж, 33 сая иргэн ажилгүй болж, эдийн засаг 4.9 хувиар агшжээ. Харин улс орнуудын хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дэлхийн хөрөнгийн зах зээл томоохон сэргэлтийг авав.



Т.Азтүшиг

Ахлах шинжээч,
Хөрөнгө
удирдлага,
судалгааны
хэлтэс



Тодруулбал, дэлхийн ихэнх улс орон цар тахлын дараах эдийн засгаа сэргээхийн тулд мөнгөний зөөлөн бодлогыг баримтлан, эдийн засгаа тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн вакцинжуулалтыг эрчимжүүлэх зэрэг ижил төстэй арга хэмжээнүүдийг авсан.



Мөнгөний
зөөлөн бодлого



Эдийн засгийг
тогтворжуулах хөтөлбөр




Вакцинжуулалтыг
идэвхижүүлэх

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ


Бодлогын хүү	1.75 -> 0.25%	4.05 -> 3.8%	10.0 -> 6.0%
Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр /ДНБ%/	0.2	0.05	0.26
Вакцинжуулалт /2-р тун/	0.617	0.745	0.659

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд дэлхийн хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 12.9 триллион ам.доллар буюу 12 хувиар өсөж, дийлэнх орны хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ өсөв.

Улс орнуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ




Дэлхийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



АНУ-ын хөрөнгийн зах зээл-2021 онд

АНУ-ын хувьд цар тахлын дэгдэлтийн дараа мөнгөний зөөлөн бодлогыг баримталж, бодлогын хүүг бууруулах, бондын худалдан авалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд энэ хүрээнд мөнгөний нийлүүлэлтийг нэмэх, вакцины хөгжүүлэлтийг хурдасгах, вакцинжуулалтыг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээг авсан.

Энэ нь тус улсын хөрөнгийн зах зээлийн голлох индекс болох S&P500 индексийг цар тахлын үе дэх ёроолын цэгээс 106 хувь өсгөх томоохон хөшүүрэг болов.



Хонгконгийн хөрөнгийн зах зээл-2021 он

БНХАУ нь АНУ-ын адилаар бодлогын хүүг бууруулах, эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, вакцины хөгжүүлэлт, вакцинжуулалтыг нэмэгдүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг авсан. Гэвч эх газрын компаниуд голдуу бүртгэлтэй байдаг Хонгконгийн хөрөнгийн биржийн Hangseng индекс уналттай байв.


Тус индекс унахад БНХАУ-ын монополийн эсрэг хуулийн хэрэгжилт болон үл хөдлөх хөрөнгийн салбарын гол тоглогч Evergrande Group-ийн хямрал, боловсролын салбарыг ашгийн төлөө бус хаалттай компани болгох зэрэг бодлогын шийдвэрүүд нь нөлөөлсөн юм.



Дэлхийн болон Монголын хөрөнгийн зах зээлд өндөр өсөлт үзүүлсэн салбар-2021 он

2021 онд тохиосон глобал эрчим хүчний салбарын хямрал нь тус салбар дахь компаниудын хувьцааны ханшийг өсгөөд зогсохгүй эрчим хүчний эрдэс бүтээгдэхүүний салбарт томоохон өсөлтийг авчирсан юм.

Мөн коронавирусын шинэ хувилбарууд бүртгэгдэж, дэлхийн хэмжээнд нийлүүлэлт саатаж, тээврийн үнэ өссөн нь тус салбарын эрэлтийг өсгөх хөшүүрэг болов. Хэдийгээр цар тахлын үед буюу 2020 онд эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн ч 2021 онд өсөлтөө хадгалж чадаагүй буюу ханшид засвар орсон байна.




Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хувьд бүх салбарын хувьцаа тэр дундаа банк, санхүүгийн салбарын компаниудын хувьцааны ханш өндөр өсөлт үзүүлэв. Тодруулбал, Мандал Даатгал ХК, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Бодь Даатгал ХК, Инвескор ББСБ ХК зэрэг компаниудын хувьцааны ханшийн өсөлтийг нэрлэж болох юм.


Дэлхийн улс орнуудын цар тахлын үед хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд ихэнх орны хөрөнгийн зах зээл тэлж, хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж буй хувьцаануудын индекс ч дагаад өсжээ.

Олон улсын хөрөнгийн биржүүдийн голлох индексүүд 4-30 хувиар өссөн бол Монгол Улсын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс 2021 онд 125 хувийн өсөлт үзүүлж тэргүүлсэн юм.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний өсөлт



Хөрөнгийн зах зээлийн индексийн өсөлт





Олон улсын Bloomberg агентлагаас Монгол Улсын ТОП-20 индексийг “The world’s hottest market in its coldest capital” хэмээн онцолсон. Үүнд Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд болон хөрөнгийн зах зээлийг дэмжсэн бодлого шийдвэрүүд нь голлох нөлөө үзүүлэв.

2022 онд дэлхийн хөрөнгийн зах зээлд учирч болох эрсдэлүүд

Bloomberg агентлагийн 700 гаруй шинжээчдийн дунд “2022 онд хөрөнгийн зах зээлд нөлөөлж болохуйц ТОП-10 эрсдэл юу вэ?” гэсэн асуулт бүхий санал асуулга явуулахад инфляц, коронавирус, дайн гэсэн эрсдэлүүдийг нэрлэсэн байна. Үүнээс инфляцийн өсөлт, Ковид 19 цар тахлын шинэ хувилбарууд, бодлогын хүү гэсэн гурван хүчин зүйлийн тохиох магадлал болон нөлөөллийг хамгийн өндөр байна гэж үзжээ.

Хөрөнгийн зах зээлд учирч болох эрсдэлүүд



Цар тахлын шинэ хувилбарууд бүртгэгдэж байгаа нь бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж, нийлүүлэлтийг саатуулан инфляцыг өсгөх гол шалтгаан болж байна.


Тодруулбал, АНУ-ын хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ 9 хувь буюу 1980 оноос хойшхи хамгийн муу үзүүлэлтэд хүрээд байна. Тиймээс АНУ-ын сенатын танхим нь ерөнхийлөгч Жое Байденийн санаачилсан эдийн засгийг сэргээх Build Back Better 1.7 триллион ам.долларын төлөвлөгөөг баталсангүй.



Инфляцын түвшин [vs] Нийлүүлэлтийн саатал



Инфляцын төсөөлөл



Дэлхийн хөрөнгийн зах зээлийн 2022 оны төлөв

2021 онд олон улсын засгийн газруудаас хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дэлхийн ихэнх улс орны хөрөнгийн зах зээл өндөр өсөлттэй байв.

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ ДНБ-ээсээ 2 дахин өндрөөр үнэлэгдэж байгаа бол ирэх онд Холбооны Нөөцийн Сангаас бодлогын хүүг 5 удаа өсгөж, бондын борлуулалтыг эхлүүлэх төлөвтэй байна. Тиймээс шинжээчид индексүүдэд идэвхтэй өсөлт үзүүлэх орон зай хумигдмал гэж үзэж байна.


Харин 2021 онд БНХАУ-аас баримталсан бодлого шийдвэрийн улмаас уналтад орсон Hang Seng индекс тодорхой хэмжээгээр сэргэх боломжтой юм.



Р.Дарханбаяр
Голомт
Капитал ҮЦК
ХХК-ийн Хөрөнгө
оруулалтын
шинжээч

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-2021

2021 онд МХБ-ийн ТОП-20 индекс 125 хувь өссөн. Тус өсөлтийн динамикийг суурь нөхцөлүүдтэй харьцуулбал, засгийн газраас цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд /бодлогын хүүг бууруулсан, хугацаагүй хадгаламжийн хүүг тэглэсэн, эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр, банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан, үнэт цаасны бүртгэлийн журам шинэчлэгдсэн/ томоохон нөлөө үзүүлсэн байна.




Монгол Улсын хөрөнгийн зах зээл хөөсөрсөн үү?


Хөгжингүй орнуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь ДНБ-ийхээ 100-200 хувьтай тэнцэхүйц өндөр байдаг бол хөгжиж буй орнуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 20-40 хувьтай байна.

Монгол Улсын хувьд хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ нь ДНБ-ий 18 хувьтай тэнцэж байгаа нь бусад улс орнуудтай харьцуулахад хөрөнгийн зах зээл тэлэх орон зай хангалттай байгааг илтгэж байна.


Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /ДНБ%/




Индексүүдийн P/S



Индексүүдийн P/B



Индексүүдийн P/E



Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаануудын үнэлгээг хөөсрөлттэй эсэхийг тогтоодог P/S, P/B, P/E үнэлгээний харьцаа үзүүлэлтүүдийг P/S болон P/B харьцаа үзүүлэлтүүд, бусад индекстэй харьцуулахад харьцангуй бага байгаа нь компаниудын хувьцааны ханш хөөсрөөгүй байх магадлалтайг илтгэж байна.

P/E харьцаа үзүүлэлт бусад улс орнуудтай харьцуулахад дундажтай ойролцоо байгаа нь компаниуд ашигт ажиллагаандаа анхаарах шаардлагатайг харуулж байна.



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн 2022 оны төлөв

2021 он дэлхийн болон Монголын хөрөнгийн зах зээлийн хувьд цар тахлын дараах сэргэлтийн он жил байсан бол 2022 онд банкнуудын IPO болон биржийн бус зах зээлийн хөгжил, эрэлттэй холбоотойгоор тэлэх төлөвтэй байна. Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаануудын үнэлгээ бусад улс орнуудтай харьцуулахад бага байгаа тул тодорхой засварын хөдөлгөөний дараа өсөх бүрэн боломжтой.

2021.01.28-нд УИХ-аас Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталж, системийн нөлөө бүхий 5 банкиг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй, олон нийтэд нээлттэй компани болох шаардлагыг хуульчилсан.

Ингэснээр 2022 онд Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 620 тэрбум ам.доллараар нэмэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүний 23.5 хувьтай тэнцэхүйц хэмжээгээр тэлэх төлөвтэй байна.

Банкны IPO

Системийн нөлөө
бүхий 5 банк

620
тэрбум ₮



Хөрөнгийн
зах зээлийн
үнэлгээ
нэмэгдэнэ

+5.6
их наяд ₮

ДНБ-д эзлэх %

~13.8%

2021 оны байдлаар

5.8

их наяд ₮

2022 онд

~23.5%

ОТС Бондын зах зээл

235.4

2021 оны 12 сарын
байдлаар

2.0%

Хувийн байгуулагад
олгосон зээлтэй
харьцуулбал

2022 онд

500-600

тэрбум ₮

2022 ОНЫ ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ГЛОБАЛ ХАГАС ДАМЖУУЛАГЧИЙН ХЯМРАЛЫГ БОЛОМЖ БОЛГОЁ

Ковид 19 цар тахлын дэгдэлтийн үед болон дараа нь хагас дамжуулагчийн эрэлт нийлүүлэлтээсээ давж дэлхийн хэмжээнд чип хомсдож хямрал үүссэн. Энэхүү хямралын улмаас автомашин үйлдвэрлэгч, график карт, видео тоглоом хөгжүүлэгч, компьютер үйлдвэрлэгчдийн чипний захиалга асар ихээр нэмэгдэж үнэ нь өсөв.

2021 онд дэлхий нийтийг хамарсан чипний хомсдол нь 169 салбарт сөргөөр нөлөөлж, автомашины салбарын орлогыг 210 тэрбум ам.доллараар агшаагаад байна. Томоохон улс гүрнүүд чипний хомсдолоос гарах, нийлүүлэлтийн гинжин хэлхээг таслахгүйн тулд дотоодын хэрэгцээгээ хангахуйц чипний үйлдвэрүүдтэй болох, үйлдвэрлэгчдийг дэмжих, чип үйлдвэрлэгч улс орнуудад нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүсэлт тавих зэрэг арга хэмжээг авсан юм.

Тухайлбал, 2021.9.23-нд АНУ-ын цагаан ордноос автомашин болон чип үйлдвэрлэгчдийн уулзалтыг зохион байгуулж, чипний хямралаас гарах арга замыг эрэлхийлсэн.

Үүний дараа буюу 2021.12.07-нд АНУ-ын Гадаад худалдааны сайд Gina Raimondo Тайваний Эдийн засгийн сайд Wang Meihua-тай уулзаж, чипний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүсэлт тавьсан билээ.

Хагас дамжуулагчийн хомсдолын автомашины салбарт үзүүлсэн нөлөө

2021.01 сар

- Форд компани Focus загварын автомашины үйлдвэрлэлээ ХБНГУ болон Louisville, Kentucky мужид зогсоолоо.
- Honda Их Британи дахь үйлдвэрээ 4 өдрийн турш хаав.

2021.02 сар

- Renault төлөвлөснөөсөө 100,000 автомашин дутуу үйлдвэрлэхээр болов.
- Stellantis компани Windsor Assembly үйлдвэрийнхээ хаалгыг түр хугацаанд барилаа.

2021.03 сар

- Honda компани Хойд Америк дахь 5 үйлдвэрээ түр хугацаанд хаав.
- Stellantis Хойд Америк дахь 5 үйлдвэрээ түр хугацаанд хаалаа.

2021.04 сар

- Форд 2021 оны хоёрдугаар улиралд автомашин үйлдвэрлэлээ 50 хувиар бууруулж, Хойд Америк дахь 6 үйлдвэрээ хаалаа.



Т.Азтүшиг

Ахлах шинжээч,
Хөрөнгө
удирдлага,
судалгааны
хэлтэс

- General Motors 1998 оноос хойш анх удаа автомашин үйлдвэрлэлээр тэргүүлэгч байр сууриа алдлаа.
- Nissan компанийн удирдлагууд 4-9 сарын хугацаанд автомашины борлуулалт 500,000-аар буурах төлөвтэй байгааг мэдэгдлээ.
- NXP Semiconductors компани Stellantis-д хагас дамжуулагч нийлүүлэх боломжгүй болсноор Итали дахь үйлдвэрлэлээ зогсоолоо.

2021.05 сар

- Форд Fiesta загварын автомашины үйлдвэрлэлээ зогсоолоо.
- General Motors автомашины үйлдвэрлэлээ 278,000 ширхгээр буурууллаа.
- Toyota Япон дахь автомашины хоёр үйлдвэрээ хаалаа.
- Jaguar Land Rover-ийн Их Британи дахь хоёр үйлдвэрээ хаалаа.
- Hyundai Tucson болон Nexo загварын автомашинуудын үйлдвэрлэлийг хязгаарлалаа.

2021.06 сар

- Toyota Япон дахь автомашины үйлдвэрлэлдээ хязгаарлалт тавилаа.
- Nissan Мексик улс дахь Kuushi болон зарим загварын автомашины үйлдвэрлэлээ зогсоолоо.
- Jaguar Словак дахь Land Rover-ийн үйлдвэрлэлээ зогсоолоо.
- Hyundai Alabama дахь үйлдвэрлэлээ хязгаарлав.

2021.07 сар

- Ford 9 үйлдвэртээ хязгаарлалт тогтоож, 2021 оны борлуулалтын орлогын таамаглалаа 2.5 тэрбум ам.доллараар буурууллаа.
- BMW чипний хомсдолтой холбоотой 10,000 ширхэг BMW болон Mini брэнд автомашинуудыг борлуулах боломжгүй болсноо мэдэгдлээ.

2021.08 сар

- General Motors 2 үйлдвэрээ хаалаа.
- Nissan Tennessee дахь үйлдвэрээ хаалаа.
- Jaguar Land Rover 53 загварын үйлдвэрлэх хугацаа 1 жилээр хойшиллоо.
- Honda Их Британи дахь үйлдвэрээ 35 жилийн дараа анх удаа хаалаа.
- Mercedes нэмэлт функцийн суурилуулалтаа багасгалаа.
- Hyundai ажлын цагаа багасгалаа.

2021.09 сар

- Toyota үйлдвэрлэлээ 40 хувиар бууруулсан нь 28 үйлдвэрлэлийн шугам, 14 үйлдвэрт нөлөөлж 360,000-аас дээш тооны автомашин үйлдвэрлэх боломжгүй болов.


Ийнхүү глобал хагас дамжуулагчийн хямралын гол хохирогчид нь томоохон үйлдвэрлэгчид болсон бол хагас дамжуулагч үйлдвэрлэгчид ихээхэн ашиг хүртсэн юм. Иймд эрэлт өндөртэй байгаа тус салбарт хөрөнгө оруулах нь хөрөнгө оруулагчдад олдож буй томоохон боломж гэхэд хилсдэхгүй юм.

Дэлхийн хагас дамжуулагчийн салбарын орлогын өсөлт

Хагас дамжуулагчийн эрэлтийг дагаж орлого нь ч хурдацтай өсөж байна. Ковид 19 цар тахал дэгдсэн цагаас иргэд гэрээс ажиллах нь нэмэгдсэн учраас компьютер болон түүний дагалдах хэрэгсэл, өгөгдлийн томоохон төвүүд, үүлэн систем, крипто олборлолттой холбоотой график карт зэргийн эрэлт өссөн.

Мөн цахилгаан автомашины шилжилт, автомат жолоодлогын системийн өрсөлдөөн нь чипний эрэлтийг нэмэгдүүлж байна.


Глобал хагас дамжуулагчийн борлуулалт сараар | тэрбум ам.доллар



Эх сурвалж: Thomson Reuters

Дээр дурдсан хүчин зүйлс нь чипний борлуулалтыг нэмэх хөшүүрэг болсон бөгөөд цар тахлын дараа дэлхийн хэмжээнд хагас дамжуулагчийн борлуулалт 44.5 хувиар өсөв.

Глобал хагас дамжуулагчийн борлуулалт бүс нутгаар | тэрбум ам.доллар



Дэлхийн хагас дамжуулагчийн нийт борлуулалтын 60-аас дээш хувийг Ази Номхон далайн орнуудад үйлдвэрлэж байна. Гол төлөөлөгчид нь дэлхийн чип үйлдвэрлэлийн 56 хувийг дангаар гүйцэтгэдэг Тайванийн Taiwan Semiconductor Manufacturing Corporation болон БНХАУ-ын чип үйлдвэрлэгч Semiconductor Manufacturing International Corporation юм.

Үүнээс үзэхэд АНУ болон Европын орнууд чипний нийлүүлэлтийн хувьд Ази Номхон далайн орнуудаас хараат байна.

Хагас дамжуулагчийн хэрэглээ

2020 онд чипний нийт хэрэглээний 32.4 хувь буюу ихэнх хувийг харилцаа холбоо, сүлжээний салбарт ашигладаг байсан бол 2021 онд өгөгдөл боловсруулалтын салбар тэргүүлж байна.

Энэ нь крипто олборлолт, үүлэн систем, metaverse буюу виртуал зах зээлийн хөгжил, өсөлттэй холбоотой.

Глобал хагас дамжуулагчийн хэрэглээ | салбараар



Хагас дамжуулагчийн хомсдол үүсэхэд:

Нийлүүлэлтийн төвөгтэй гинжин хэлхээтэй тус салбарт тээвэрлэлтийн саатал өссөн

Covid 19

Крипто валютын зах зээлийн хэмжээ томрох тусам крипто олборлогчдын чипний эрэлт нэмэгдсэн

Crypto Mining

Автомат жолоодлоготой цахилгаан автомашины эрин үеийг дагаад нэгж автомашинд ашиглагдах чипний хэмжээ нэмэгдсэн

Self Driving EV

Эх сурвалж: Fortune Business Insight


Цаашид 5G сүлжээний дараагийн үе, үүлэн систем, крипто олборлолтоос шалтгаалсан дата процесс, цахилгаан болон автомат жолоодлогын систем зэрэг инновацид чиглэсэн бүтээгдэхүүнүүдийн хөгжүүлэлтээс шалтгаалан чипний эрэлт өсөх төлөвтэй байна.

Хагас дамжуулагчийн нийлүүлэлтийн гинжин хэлхээ

Хагас дамжуулагчийн эрэлт өндөр байгаа нь нийлүүлэлт саатах, хомсдол үүсэх гол шалтгаан болсон. Энэ нь тус салбарын компаниудад өсөлтийн хөшүүрэг болж байна.

The global supply chain of a smartphone processor

Semiconductor production involves hundreds of different materials and processes, with pieces of the supply chain spanning the globe.



Нийлүүлэлтийн процесс

түүхий эд, дизайн, үйлдвэрлэл, тоног төхөөрөмж, баглаа боодол тест, хүргэлт

100 өдөр

Хилийн зурвасаар дамжих /эцсийн бүтээгдэхүүн худалдан авагчийн гарт хүрэх хүртэл/

70 гаруй удаа

Тээвэрлэлт /транзит/

12 өдөр

Эх сурвалж: АНУ-ын Худалдааны яамны хагас дамжуулагчийн салбарын 100 өдрийн үнэлгээний тайлан


Нийлүүлэлтийн гинжин хэлхээний нүсэр бүтэцтэй хагас дамжуулагчийн салбарын хувьд тээвэрлэлт саатах эрсдэл өндөр юм. Энэ нь хомсдол үүсэх, компаниудын чип худалдан авах дараалал үүсэх, чипний үнэ өсөх гол шалтгаан болж байна.

9 сард чип үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэгч Taiwan Semiconductor Manufacturing компани бүтээгдэхүүний үнээ 20 хувиар өсгөхөө мэдэгдсэн нь 2022 онд чипний үнэ буурахгүйг илтгэж байна.

Хагас дамжуулагчийн салбарын үнэлгээ харьцуулалт


Хагас дамжуулагчийн салбарын үнэлгээг эдийн засгийн 11 секторын 140 салбартай харьцуулж үзэхэд нийт зах зээлийн эхний гуравт багтаж байна. Гэвч тус салбарт хамаарах компаниудын үнэлгээний харьцаа үзүүлэлтүүд дунджаас доогуур байна.

Салбарын харьцаа үзүүлэлт | Market Cap+P/E



Дундаж үзүүлэлт	Market Cap	P/E	P/B	Sales past 5Y
Average	483.7	45.5	5.3	7.4%
Median	181	16.5	3.2	5.3%
Semiconductor	3,225.6	33.5	5.0	15.5%

Салбарын харьцаа үзүүлэлт | P/E+P/B



- 11 Секторын 140 Салбар
- Зах зээлийн үнэлгээгээр эхний 3-т
- Үнэлгээ (P/E+P/B) дунджаас доогуур
- Үнэлгээ (P/E+P/B) медианаас дээгүүр

- $P/S = \text{Price} / \text{Sales}$, Sales >>> Total Sales/Outstanding shares
- $P/B = \text{Price} / \text{Book value}$ >>> Equity/Outstanding shares

Нэг төгрөгийн орлогыг та хэдэн төгрөгөөр авч байна вэ?


Харьцаанууд хэт өндөр байх нь хэт өөдрөг байдал эсвэл хөөсрөлийг, хэт бага байх нь компанийн ирээдүйг гутрангиар эсвэл хямдхан байгааг харуулж байна гэсэн үг.

Сектор болон салбаруудтай харьцуулсан харьцаа үзүүлэлтүүдийг харахад хагас дамжуулагчийн салбар нь хөөсрөлттэй бус хөрөнгө оруулахад боломжийн гэж дүгнэхүйц байна.

Хагас дамжуулагч болон технологийн салбарын үнэлгээ, харьцуулалт


Хагас дамжуулагчийн салбарыг технологийн 12 салбартай харьцуулж үзэхэд зах зээлийн нийт үнэлгээгээр эхний хоёрт багтаж байна. Гэвч тус салбарт хамаарах компаниудын үнэлгээний харьцаа үзүүлэлтүүд дунджаас доогуур байна.

Технологийн сектор дахь салбаруудын харьцаа | Market Cap+P/E



Дундаж үзүүлэлт	Market Cap	P/E	P/B	Sales past 5Y
Average	1,379.3	39.1	7.6	11.5%
Median	625.2	32.0	4.5	9.8%
Semiconductor	3,225.6	33.5	5.0	15.4%

Технологийн сектор дахь салбаруудын харьцаа | P/E+P/B




- Технологийн Секторын 12 Салбар
- Зах зээлийн үнэлгээгээр эхний 2-т
- Үнэлгээ (P/E+P/B) дунджаас доогуур
- Үнэлгээ (P/E+P/B) медианаас дээгүүр

Хагас дамжуулагчийн салбарт хөрөнгө оруулж болохуйц бүтээгдэхүүнүүд

Дэлхийн хагас дамжуулагчийн болон чип үйлдвэрлэлийн зах зээлийн 87 хувийг Ази Номхон далайн орнууд бүрдүүлдэг. Үүний дийлэнх буюу 63 хувийг Тайвань улс дангаар үйлдвэрлэдэг байна.

Чипний үйлдвэр | Эзлэх хувь



Харин дэлхийн хэрэгцээний нийт чип үйлдвэрлэлийн 53 хувийг Тайвань улсын Taiwan Semiconductor Manufacturing компани үйлдвэрлэж байна.

Үүний дараа зах зээлийн 17 хувийг БНСУ-ын Samsung компани, БНХАУ-ын Semiconductor Manufacturing International Corporation /0981.HK/ 5 хувийг бүрдүүлдэг.



TAIWAN SEMICONDUCTOR MANUFACTURING | TSM.NYSE

Дэлхийн хамгийн анхны хагас дамжуулагч үйлдвэрлэгч Taiwan Semiconductor Manufacturing /TSM.NYSE/ компани нь Ази, Европ, Хойд Америкт үйл ажиллагаа явуулдаг, 2020 оны байдлаар 510 гаруй байгууллагад бүтээгдэхүүнээ нийлүүлж байна.

Apple, Intel, Nvidia, AMD, Qualcomm, Huawei, Broadcom, Google, Amazon зэрэг дэлхийд алдартай томоохон компаниуд гол хэрэглэгчид нь юм.



NVIDIA



Qualcomm



HUAWEI



BROADCOM



amazon

Тус компани нь зах зээлийн үнэлгээгээр дэлхийд Meta Platform /Facebook/, Berkshire Hathaway, Nvidia-ийн дараа 10-т ордог асар өндөр үнэ цэнтэй компани юм.

Taiwan Semiconductor Manufacturing /TSM.NYSE/ компанийн онцлох мэдээллүүд

- Тус компани АНУ-ын Аризона мужид 5 нанометр хэмжээтэй чип үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг 2024 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Тус үйлдвэр нь 12 тэрбум ам.долларын өртөгтэйгөөр баригдаж байгаа бөгөөд сард 20,000 ширхэг чип үйлдвэрлэх юм.
- 2021.12.7-нд АНУ-ын гадаад худалдааны сайд Gina Raimondo Тайваний эдийн засгийн сайд Wang Meihua-тай уулзаж хоёр улсын чипний худалдааны хэмжээг нэмэгдүүлэх хүсэлт тавьсан.
- Тус компани Япон улсад 8.8 тэрбум ам.долларын өртөг бүхий үйлдвэрийг 2024 онд ашиглалтад оруулахаар зорьж байна. Барилгын ажил 2022 онд эхлэхээр хүлээгдэж байгаа бөгөөд Японы Ерөнхий сайд Fumio Kishida, TSM шиг хувийн хэвшлийн гадаадын шууд хөрөнгө оруулалттай компанийг дэмжиж ажиллана гэдгээ мэдэгдсэн байна.

Taiwan Semiconductor Manufacturing | TSM.NYSE | хувьцааны ханшийн үзүүлэлт

Taiwan Semiconductor Manufacturing | TSM.NYSE

Хугацаа	1 жил	3 жил	5 жил	10 жил
Ханшийн өсөлт /жилийн дундаж/	12.30%	80.60%	62.30%	85.70%
Ногдол ашгийн өгөөж /тухайн жилд/	1.30%	2.72%	2.51%	2.76%


Цар тахлын үед буюу хагас дамжуулагчийн хомсдол өндөр байх үед /2020.01 хүртэл/ тус компанийн хувьцааны ханш 125.4 хувиар өсөж түүхэн дээд амжилтыг тогтоосон юм.

Дэлхийн томоохоон хөрөнгө оруулалтын банкнууд хагас дамжуулагчийн салбарын хомсдол 2022 оны эхний хагас хүртэл үргэлжилж, цаашид ч эрэлт өндөр байх төлөвтэй байгаа учраас хувьцааны ханш нь өсөх боломжтой гэж үзэж байна.


Хөрөнгө оруулалтын бүтэц задаргаа

Тус компанийн нийт хөрөнгө оруулагчдын 17 хувь нь сангийн менежерүүд юм. Хөрөнгө оруулалтын эргэцийг харвал 82 хувь нь урт хугацаанд эзэмшлээ хадгалж байна.


Хөрөнгө оруулагчид




Хөрөнгө оруулалтын бүтэц | улсаар



Хөрөнгө оруулалтын төрлөөр



Хөрөнгө оруулалтын эргэц



TOP 10 хөрөнгө оруулагчид

Топ 10 хөрөнгө оруулагчид	Эзэмшил /хувь	Эзэмшил /сая ширхэг	Өөрчлөлт	Х/о-ийн төрөл
Sanders Capital LLC	0.81%	41.89	1.45	Сангийн удирдлага
Capital World Investors	0.68%	35.51	-0.06	
Capital International Investors	0.61%	31.69	-2.92	
MFS Investment Management	0.59%	30.67	-0.69	
WCM Investment Management	0.50%	26.06	0.24	
Walter Scott & Partners Ltd	0.49%	25.63	-0.91	
Fisher Investments	0.49%	25.38	-0.6	
The Vanguard Group	0.38%	19.53	-2	
JP Morgan Asset Management	0.37%	19.03	0.01	
T.Rowe Price Associates Inc	0.33%	17.09	4.71	


Эх сурвалж: Thomson Reuters

Санхүүгийн эрүүл мэнд


Цар тахлын үед ч тус компанийн ашигт ажиллагаа, борлуулалтын орлого, цэвэр ашиг нь хурдацтай өссөн.

Мөн энэ хугацаанд өр төлбөр барагдуулах болон хөшүүргийн харьцаа үзүүлэлтүүд хэвийн түвшинд байж нийт хөрөнгө болон эздийн өмчид ногдох өгөөжийн хэмжээ тогтмол өссөн нь санхүүгийн хувьд эрүүл байгааг илтгэж байна.

Баланс | тэрбум ам.доллар



Орлогын тайлан | тэрбум ам.доллар



сая ам.доллараар	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Сүүлийн 12 сар	Таамаглал	Таамаглал
Сүүлийн 12 сар	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2021	2022
Эргэлтийн хөрөнгө	22,756	25,208	28,899	31,138	27,504	38,903	49,285		
Эргэлтийн бус хөрөнгө	27,755	32,946	38,253	37,249	48,220	59,431	70,538		
Нийт хөрөнгө	50,511	58,154	67,152	68,387	75,724	98,334	119,823		
Нийт өр төлбөр	13,282	15,327	15,839	13,523	21,512	32,451	45,174		
Нийт эздийн өмч	37,229	42,826	51,313	54,864	54,212	65,883	74,650		
Борлуулалтын орлого	26,570	29,412	32,145	34,233	34,644	45,484	53,788	56,799	74,393
Нийт ашиг	12,927	14,734	16,274	16,527	15,953	24,152	27,914	29,150	34,988
Цэвэр ашиг	9,657	10,371	11,284	11,653	11,179	17,588	20,403	21,322	29,475
Чөлөөт мөнгөн урсгал	8,444	6,440	8,230	8,339	4,707	10,388	10,477		
Эргэлтийн харьцаа	3.52	2.57	2.39	2.79	1.39	1.77	2.09		
Өр ба хөрөнгийн харьцаа	0.26	0.26	0.24	0.2	0.28	0.33	0.38		
Хөрөнгийн эргэц	0.13	0.15	0.14	0.14	0.14	0.13	0.13		
Нийт ахиуц ашиг	48.70%	50.10%	50.60%	48.30%	46.00%	53.10%	51.90%		
Цэвэр ахиуц ашиг	36.30%	35.30%	35.10%	34.00%	32.30%	38.70%	37.90%		
Санхүүгийн хөшүүрэг	1.36	1.36	1.31	1.25	1.4	1.49	1.61		
Нийт хөрөнгийн өгөөж	19.10%	17.80%	16.80%	17.00%	14.80%	17.90%	17.00%	18.7	18.2
Нийт эздийн өмчийн өгөөж	25.90%	24.20%	22.00%	21.20%	20.60%	26.70%	27.30%	28.69	27.7
Ногдол ашгийн дундаж өгөөж	4.10%	2.90%	2.50%	2.70%	2.20%	1.30%	1.30%		
P/S	4.4	4.96	6.09	5.67	8.02	10.26	9.96	10.63	8.12
P/B	3.04	3.39	3.91	3.49	5.29	7.43	7.24		
P/E	12.1	14.1	17.3	16.7	24.9	26.5	26.2	30.4	24.9
Ажилчдын тоо							52,045		
Нэг ажилтанд ногдох орлого							25.9		

Эх сурвалж: Thomson Reuters


Хувьцааны үнэлгээ Neutral

Үнэлгээний P/S, P/B, P/E харьцаа үзүүлэлтүүд түүхэн үзүүлэлтүүдээс өндөр байна. Гэхдээ P/E харьцаа үзүүлэлт салбарын дундажтайгаа харьцуулахад бага байгаа нь өрсөлдөгч компаниудаасаа багаар үнэлэгдсэн байх магадлалтай юм.

Үнэлгээний харьцаа | түүхэн үзүүлэлт



Үнэлгээний харьцаа | салбарын дундажтай харьцуулснаар



А.Билгүүн

Техник
шинжээч,
Хөрөнгө
удирдлага,
судалгааны
хэлтэс

Техник шинжилгээ | TSM.NYSE




Зураг 1 | сүүлийн 3 жилийн лаан чарт

Зураг 1, Тус компанийн хувьцааны ханшийн өсөлт ханасан төлөв ажиглагдаж байна. Богино хугацаанд уналт үргэлжлэх ба 110 орчимд хүрэх магадлал өндөр байна. 107-оос 110-ын хооронд байрлах дэмжлэгийн бүсээс амжилттай дэмжлэг авч чадвал дээшээ өсөлтөөр 120 хүрэх боломжтой. Эсрэгээрээ тус бүсийг сэтэлбэл хүчтэй уналт үргэлжилнэ.

Олон улсын хөрөнгө оруулалтын банкнуудын шинжээчдийн таамаглал

Олон улсын агентлаг Reuters агентлагт-д нийт 10 хөрөнгө оруулалтын 10 шинжээч ид өөрсдийн таамаглалыгаа явуулсан илгээснээс 3 нь тус компанийн хувьцааг худалдан авахад маш тохиромжтой, 4 нь худалдан авахад тохиромжтой, 3 нь эзэмшлээ барьж үлдэх гэсэн зөвлөгөөг нүүдийг өгсөн бол дундаж зорилтот ханшийг 145.23 ам.доллар хүрнэ гэж таамаглажээ.




Эх сурвалж: Thomson Reuters

ESG Score

Байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээ

Taiwan Semiconductor Manufacturing компанийн ESG үнэлгээ нь салбарын дундажтай харьцуулахад өндөр байна. Үүнийг өрсөлдөгчидтэй нь харьцуулахад байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг, нийгмийн хариуцлага, компанийн засаглал сайтайг илтгэж байна.

ESG Combined score | салбарын дундажтай харьцуулснаар



Taiwan Semiconductor Manufacturing Co Ltd 11-Jan-2022 1:56:07 PM					
Environment					
	2020	2019	2018	2017	2016
Period End Date	2020-12-31	2019-12-31	2018-12-31	2017-12-31	2016-12-31
Reporting Currency	TWD	TWD	TWD	TWD	TWD
Period Status	Complete	Complete	Complete	Complete	Complete
ESG Report	Yes	Yes	Yes	Yes	Yes
ESG Reporting Scope	100%	100%	89.20%	89.30%	90.53%
ESG Report Auditor Name	DNV GL Business Assurance Co. Ltd.	DNV GL Business assurance Co. Ltd.	DNV GL	DNV GL	DNV GL
ESG Combined Score	A-	A-	A	A	A
ESG Score (Weight 100.0%)	A-	A-	A	A	A
Environmental Pillar Score (Weight 31.2%)	B+	B+	A	A	A
Social Pillar Score (Weight 42.9%)	A+	A	A+	A+	A
Governance Pillar Score (Weight 26.0%)	B+	A-	A-	A	A
ESG Controversies Score	A+	A-	A+	A	A+
Resource Use Score (Weight 9.5%)	A+	A+	A+	A+	A+

Эх сурвалж: Thomson Reuters

Дүгнэлт

Taiwan Semiconductor Manufacturing /TSM.NYSE/ компани нь салбартаа монопол гэж хэлж болохуйц гол тоглогч бөгөөд өрсөлдөөний хувьд асар том давуу талтай юм. Мөн капиталын зардлыг нэмэгдүүлж, үйлдвэрлэлээ өргөжүүлж байгаа нь хомсдолтой байгаа зах зээлд үр ашигтай ажиллах боломжтойг илтгэж байна.

Зах зээлд эрчимтэй өсөлт үзүүлэхэд шаардлагатай суурь нөхцөл бүрдсэн, санхүүгийн хувьд эрүүл компани бөгөөд өрсөлдөгч компаниудтай нь харьцуулахад багаар үнэлэгдсэн байна.



Т.Азтүшиг

Ахлах шинжээч,
Хөрөнгө
удирдлага,
судалгааны
хэлтэс

SEMICONDUCTOR MANUFACTURING INTERNATIONAL.Corp | 0981.HK

БНХАУ-ын чип үйлдвэрлэгч төрийн өмчит хамгийн том компани болох Semiconductor Manufacturing International Corp /SMIC/ нь 2000 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд дэлхийн чип үйлдвэрлэлийн зах зээлийн 5 хувийг дангаар хангаж байна.

Тус компани нь БНХАУ, Хонгконг, Япон, АНУ, Европын орнуудад үйл ажиллагаа явуулдаг.

Huawei Technologies, Qualcomm, Apple, Samsung Electronics, Silicon Laboratories зэрэг дэлхийн хэмжээний томоохон компаниудтай хамтран ажилладаг.



Qualcomm



HUAWEI



BROADCOM®



SILICON LABS

SMIC компанийн чипний үйлдвэрүүд нь БНХАУ-ын Beijing, Tianjin, Shenzhen, Guangdong, Shanghai, Jiangyin, Jiangsu зэрэг хотуудад байрладаг бол харилцагчийн үйлчилгээ болон маркетингийн оффисууд нь АНУ, Европ, Япон, Тайван, Хонгконг зэрэг улсад үйл ажиллагаа явуулдаг.

Тус компанийн хувьцаа Хонгконг болон Шанхайн хөрөнгийн биржид арилжаалагддаг.

Semiconductor Manufacturing International Corp /0981.HK/ компанийн онцлох мэдээллүүд

- БНХАУ нь өөрсдийн үйлдвэрлэлээр дотоодын хэрэгцээнийхээ 16 хувийг хангадаг бөгөөд дэлхийн нийт чипний хэрэглээний 60 хувийг хэрэглэдэг. Төрөөс хэрэгжүүлж буй Made in China зорилтын хүрээнд 2025 он гэхэд дотоодын чипний хэрэгцээний 70 хувийг дотоодын үйлдвэрлэгчдээс хангах зорилтыг тавиад байна.
- 2019 онд БНХАУ нь Made in China зорилтыг дэвшүүлж, чип үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд The China Integrated Circuit Industry Investment Fund-д 140 тэрбум юанийг татан төвлөрүүлсэн юм.
- Тус компани 2021.09.03 өдөр хийсэн мэдэгдэлдээ Шанхайд шинээр баригдаж буй үйлдвэрийг ашиглалтад оруулахад 8.87 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг дурджээ. Тус үйлдвэр ашиглалтад орсноор сард 100,000 ширхэг 12 инчийн ялтаст чип үйлдвэрлэх юм.
- 2021 оны 3 сард SMIC Shenzhen хотод сард 40,000 ширхэг 12 инчийн ялтаст чип үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барьж эхэлснээ мэдэгдсэн бөгөөд 2.35 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх юм байна.

Semiconductor Manufacturing International Corp /0981.HK/ ханшийн үзүүлэлт

Semiconductor Manufacturing International Corp /0981.HK/


Хугацаа	1 жил	3 жил	5 жил	10 жил
Ханшийн өсөлт /жилийн дундаж/	-16.70%	58%	16.50%	38%

Цар тахлын үед буюу хагас дамжуулагчийн хомсдол өндөр байхад /2020.01-2021.01/ тус компанийн хувьцааны ханш 84 хувиар өссөн. Цаашид Made in China санаачилгын хүрээнд хагас дамжуулагчийн эрэлт өндөр байх төлөвтэй байгаа учраас ханш өсөх бүрэн боломжтой юм.


Хөрөнгө оруулалтын бүтэц задаргаа

Нийт хөрөнгө оруулагчдын 15.5 хувь нь стратегийн хөрөнгө оруулагч, 17.1 хувь нь сангийн менежерүүд байна. Хөрөнгө оруулалтын эргэцийг харвал ихэнх хөрөнгө оруулагчид урт хугацаанд эзэмшлээ хадгалж байна.


Хөрөнгө оруулагчид




Хөрөнгө оруулалтын бүтэц | улсаар



Хөрөнгө оруулалтын төрлөөр



Хөрөнгө оруулалтын эргэц




TOP 10 хөрөнгө оруулагчид

Топ 10 хөрөнгө оруулагчид	Эзэмшил /хувь/	Эзэмшил /сая ширхэг/	Өөрчлөлт /сая ширхэг/	Х/о-ийн төрөл
Datang Telecom Technology & Industry Holdings	15.51%	924.99	-7	Стратегийн хөрөнгө оруулагч
China Integrated Circuit Industry Investment Fund	10.35%	617.21	-88.02	
E Fund Management	0.64%	38.28	10.73	Сангийн удирдлага
Norges Bank Investment Management	0.54%	32.28	-16.37	
Fullgoal Fund Management	0.51%	30.67	23.6	
CSOP Asset Management Limited	0.46%	27.23	2.22	
China Asset Management	0.44%	26.48	26.47	
Blackrock Asset Management	0.43%	25.62	-0.07	
HuaAn Fund Management	0.41%	24.43	20.66	
Invesco Great Wall Fund Management	0.38%	22.82	22.82	


Санхүүгийн эрүүл мэнд

Цар тахлын үед тус компанийн ашигт ажиллагаа алдагдаагүй бөгөөд борлуулалтын орлого, болон цэвэр ашиг нь хурдацтай өсөж байх үед ашгийн маржин алдагдаагүй. Мөн энэ хугацаанд өр төлбөр болон хөшүүргийн харьцаа үзүүлэлтүүд хэвийн түвшинд байж, нийт хөрөнгө болон эздийн өмчид ногдох өгөөжийн хэмжээ тогтмол өссөн нь санхүүгийн хувьд эрүүл байгааг илтгэж байна.

Баланс | тэрбум ам.доллар



Орлогын тайлан | тэрбум ам.доллар




сая ам.доллараар	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Бодит	Сүүлийн 12 сар	Таамаглал	Таамаглал
Сүүлийн 12 сар	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2021	2022
Эргэлтийн хөрөнгө	2,590	3,684	4,169	6,150	6,874	15,171	14,327		
Эргэлтийн бус хөрөнгө	4,525	6,431	7,749	8,274	9,564	16,150	18,933		
Нийт хөрөнгө	7,115	10,115	11,918	14,424	16,438	31,321	33,260		
Нийт өр төлбөр	3,385	5,965	6,685	8,407	10,205	16,146	16,759		
Нийт эздийн өмч	3,730	4,151	5,233	6,018	6,233	15,175	16,501		
Борлуулалтын орлого	2,236	2,914	3,101	3,360	3,116	3,907	4,844	5,428	6,283
Нийт ашиг	683	850	741	747	643	921	1,300	1,610	1,889
Цэвэр ашиг	253	377	180	134	235	716	1,425	1,523	1,284
Чөлөөт мөнгөн урсгал	-591	-1,865	-1,250	-1,019	-862	-3,624	-1,879	-1,621	-1,196
Эргэлтийн харьцаа	1.47	1.86	2.19	2.15	2.14	3.9	3.67		
Өр ба хөрөнгийн харьцаа	0.48	0.59	0.56	0.58	0.62	0.52	0.5		
Хөрөнгийн эргэц	0.09	0.08	0.07	0.06	0.05	0.03	0.04		
Нийт ахиуц ашиг	30.50%	29.20%	23.90%	22.20%	20.60%	23.60%	26.80%		
Цэвэр ахиуц ашиг	11.30%	12.90%	5.80%	4.00%	7.50%	18.30%	29.40%		
Санхүүгийн хөшүүрэг	1.91	2.44	2.28	2.4	2.64	2.06	2.02		
Нийт хөрөнгийн өгөөж	3.60%	3.70%	1.50%	0.90%	1.40%	2.30%	4.30%	4.30%	3.50%
Нийт эздийн өмчийн өгөөж	6.80%	9.10%	3.40%	2.20%	3.80%	4.70%	8.60%	8.90%	6.90%
Ногдол ашгийн дундаж өгөөж									
P/S	2.07	2.69	2.88	1.3	3.38	5.59	4.64	5.53	4.78
P/B	1.15	1.61	1.63	0.73	1.24	1.45	1.36	1.06	0.99
P/E	17.2	19	49.5	34.2	37.4	27.2	15.7	12.2	14.6
Ажилчдын тоо							17,354		
Нэг ажилтанд ногдох орлого							0.32		

Хувьцааны үнэлгээ


Багаар үнэлэгдсэн | Undervalued

Үнэлгээний P/S, P/B, P/E харьцаа үзүүлэлтүүд түүхэн үзүүлэлтүүдээс өндөр байна. Гэхдээ P/E харьцаа үзүүлэлт салбарын дундажтайгаа харьцуулахад бага байгаа нь өрсөлдөгч компаниудаас багаар үнэлэгдсэн байх магадлалтай юм.

Үнэлгээний харьцаа | түүхэн үзүүлэлт



Үнэлгээний харьцаа | салбарын дундажтай харьцуулснаар



Техник шинжилгээ | SMIC 0981.HK



Зураг 2 | сүүлийн 7 жилийн лаан чарт

Хамгийн ойр байрлах хүчтэй дэмжлэгийн бүс нь 12.15 HKD орчимд байна. Тиймээс тухайн компанийн ханш одоогийн байгаа цэгээс 12.15 HKD хүртэл унаад тухайн бүсээс дэмжлэг авч эргэж өсөх магадлал өндөр байна. Урт хугацаандаа хувьцааны ханш 33 HKD хүрэх бүрэн боломжтой.




А.Билгүүн


Техник
шинжээч,
Хөрөнгө
удирдлага,
судалгааны
хэлтэс

Олон улсын хөрөнгө оруулалтын банкнуудын шинжээчдийн таамаглал

Олон улсын агентлаг Reuters агентлагт-д нийт 28 хөрөнгө оруулалтын шинжээчид өөрсдийн таамаглалаа ирүүлснээс 7 нь худалдан авахад маш тохиромжтой, 7 нь худалдан авахад тохиромжтой, 10 нь эзэмшлээ барьж үлдэх, 2 нь зарах, 2 нь зарахад маш тохиромжтой гэсэн зөвлөгөөнүүдийг өгсөн бол дундаж зорилтот ханшийг 29.33 хонгконг доллар хүрнэ гэж таамагласан байна.



ESG Combined score | салбарын дундажтай харьцуулснаар



Semiconductor Manufacturing International Corp 11-Jan-2022 5:55:30 PM					
Environment					
	2020	2019	2018	2017	2016
Period End Date	2020-12-31	2019-12-31	2018-12-31	2017-12-31	2016-12-31
Reporting Currency	USD	USD	USD	USD	USD
Period Status	Complete	Complete	Complete	Complete	Complete
ESG Report	Yes	Yes	Yes	Yes	Yes
ESG Reporting Scope	100%	100%	100%	97.86%	100%
ESG Report Auditor Name	-	-	-	-	-
ESG Combined Score	B-	B-	B-	B-	B-
ESG Score (Weight 100.0%)	B-	B-	B-	B-	B-
Environmental Pillar Score (Weight 31.2%)	C+	C+	C	C	C
Social Pillar Score (Weight 42.9%)	B	B+	B+	B+	B
Governance Pillar Score (Weight 26.0%)	C+	B-	B-	C+	C+
ESG Controversies Score	A+	A+	A+	A+	A+
Resource Use Score (Weight 9.5%)	B+	B	B	B	B

Эх сурвалж: Thomson Reuters

Дүгнэлт

БНХАУ-ын төрийн өмчит хагас дамжуулагч үйлдвэрлэгч томоохон компани болох Semiconductor Manufacturing International Corp /0981.HK/ нь засгийн газрын Made in China санаачилгын хүрээнд ирэх жилүүдэд томоохон өсөлт үзүүлэх боломжтой байна.

Зах зээлд эрчимтэй өсөлт үзүүлэхэд шаардлагатай суурь нөхцөл нь бүрдсэн, санхүүгийн хувьд хангалттай эрүүл компани бөгөөд өрсөлдөгч компаниудтай нь харьцуулахад багаар үнэлэгджээ.

Мөн олон улсын томоохон хөрөнгө оруулалтын банкнуудын шинжээчид худалдан авахад тохиромжтой гэж үзэж байгаагаас гадна техник шинжилгээний үр дүнд үе шаттайгаар худалдан авалт хийж эхлэхэд тохиромжтой цэг дээр байна.



Т.Азтүшиг

Ахлах шинжээч,
Хөрөнгө
удирдлага,
судалгааны
хэлтэс

BLACKROCK ISHARES SEMICONDUCTOR ETF | SOXX.NASDAQ

Дэлхийд алдартай хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын компани болох Blackrock компанийн iShares Semiconductor ETF /SOXX.NASDAQ/ нь хагас дамжуулагчийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудаас бүрдсэн ETF юм.

ТОП хөрөнгө оруулагчдад дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын сангууд багтаж байгаа нь тус зах зээлийг урт хугацаанд тогтвортой өсөлтөө хадгалах боломжтойг илтгэж байна.


BlackRock iShares Semiconductor ETF SOXX.NASDAQ

Period	1 year	3 year	5 year	10 year
Total	47.50%	35.60%	33.10%	27.10%
Return (%)				

Top Holders

Bofa Global Research	4.10%
Morgan Stanley Smith Barney LLC	2.20%
Citi Investment Research	1.96%
UBS Financial Services	1.73%
Wells Fargo Advisors	1.09%
Fisher Investments	0.98%
Goldman Sachs & Company Inc	0.77%

TOP Holdings




СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ИРЭЭДҮЙ


Дэлхий нийт 2021 оны байдлаар 26,700 ТВЦ (Террават цаг) хэмжээтэй эрчим хүчийг хэрэглэжээ. Үүнд сэргээгдэх эрчим хүч болон усны хэрэглээ 11.4 хувийг эзэлдэг.

Цар тахлын үеийн эдийн засгийн хямралын үед дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээ 5 хувиар буурсан бол сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ 7 хувийн өсөлттэй байжээ. Өөрөөр хэлбэл хямралын үед ч сэргээгдэх эрчим хүчний салбар өсөлттэй байгаа нь тус зах зээл томоохон нөөц боломжтойг илтгэж байна.

Дэлхийн нийт эрчим хүчний хэрэглээ



Сэргээгдэх эрчим хүчний зах зээл




М.Чинсанаа
Шинжээч

БНХАУ нь Paris Climate Agreement and Rainforest Conservation үеэр 2030 он гэхэд агаарын бохирдлыг 60-65 хувиар бууруулах зорилт тавьснаа зарласан.


БНХАУ нь агаарын бохирдлын 11 гига тонн буюу дэлхийн нийт нүүрсхүчлийн хийн 24 хувийг дангаар ялгаруулж байна.

Харин БНХАУ-ын дарга Ши Жиньпин НҮБ-ийн чуулга уулзалтын үеэр БНХАУ 2060 он гэхэд агаарын бохирдлыг бүрэн тэглэх төлөвлөгөөтэй байгааг мэдэгдсэн юм.

Дэлхийн эрчим хүчний хэрэглээг хангах байдал



2025 оныг хүртэл салбарын өсөлтийг хангах бүтээгдэхүүн




Ирэх 5 жилд дэлхийн улс орнууд эрчим хүчний нийт хэрэглээнийхээ 99 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шийдэх төлөвтэй байна.

Сэргээгдэх эрчим хүчний нийт ялгаруулалт ирэх 5 жилд 50 хувь өсөж, 9745 ТВЦ хүрэхээр байгаа юм. Тэр дундаа нар болон салхины эрчим хүчинд тулгуурласан шийдэл хамгийн өндөр буюу нийт хэрэглээний 70 хувийг бүрдүүлнэ.

Бүтээгдэхүүн бүрийн нэмэлт суурьлуулалт | глобал



2025 оныг хүртэл салбарын өсөлтийг хангах бүтээгдэхүүн




2025 он гэхэд сэргээгдэх эрчим хүч, тэр дундаа нар болон салхины цахилгаан эрчим хүчний хэрэглээ тэргүүлэгч байр сууринд хүрнэ. Тодруулбал, энэ хослолын жилийн хэрэглээ 4000 ТВЦ хүрч одоогийнхоос 2 дахин өсөхөөр байна.


Салхи болон нарнаас үйлдвэрлэх эрчим хүчний чадамж нь 2148ГВ (Гигават) болох бөгөөд энэ нь хамгийн өндөр дулаан ялгаруулалттай нүүрсийг 44GW-аар давсан үзүүлэлт юм.

Ингэснээр дэлхийн нийт хэрэглээний 27 хувийг бүрдүүлдэг нүүрс нь байр сууриа алдах төлөвтэй байна.

2021, 2022 оны нэмэлт нар, салхины эрчим хүч



Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ | Хятад болон бусад



Ирэх 5 жилд сэргээгдэх эрчим хүчний салбарын 50-60 хувь нь БНХАУ-д үйлдвэрлэгдэхээр байна. Тиймээс тус улсад үйл ажиллагаагаа явуулдаг компанид хөрөнгө оруулах нь ухаалаг шийдвэр болох өндөр магадлалтай юм.

Учир нь БНХАУ нь ирэх 5 жилд 900TWH сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй болох төлөвтэй байгаа ч цаана нь 1300 ТВЦ-ийн хэрэглээг хангаж чадахгүйд хүрэх юм. Тиймээс энэ орон зайг нүүрс болон бусад бүтээгдэхүүнээр нөхөхөөр байна.

АНУ-ын хувьд 108 ТВЦ сэргээгдэх эрчим хүчний шинэ хэрэглээ үүснэ. Тиймээс тус улс 420 ТВЦ буюу хэрэглээнээсээ 4 дахин их сэргээгдэх эрчим хүчээр хүчин чадлаа нэмэгдүүлэхээр зорьж байна. Энэ нь дотоод дахь нүүрсний хэрэглээг танахаас гадна бусад орон руу экспортлох зорилготой нь холбоотой.

Европын орнуудын хувьд мөн адил хэрэглээнээсээ 9 дахин их буюу 410 TWH-аар хүчин чадлаа нэмэхээр зорьж байна.

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БОЛОМЖИТ БҮТЭЭГДЭХҮҮН

XINYI SOLAR HOLDINGS LTD /0968.HK/

БНХАУ-ын Xinyi Solar компани нь нарны хавтангийн шил үйлдвэрлэдэг Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй компани юм. Борлуулалтын орлогын 80 хувийг хавтангийн шилний борлуулалт эзэлдэг бол 20 хувийг нь орон нутагт суурилуулсан нарны цахилгаан станцын түгээлтийн орлого бүрдүүлдэг.

БНХАУ-д нарны цахилгаан станцын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 18 компани байдгаас хамгийн өндөр борлуулалтын өсөлттэй, эерэг мөнгөн урсгалтай цорын ганц компани юм.

Дийлэнх сэргээгдэх эрчим хүчний компани ашиггүй ажилладаг бөгөөд ирээдүйд ашиг олно гэж тайлбарладаг. Харин Xinyi Solar-ийн хувьд бусдадаа ашигтай ажиллах боломжтойг нотлон харуулж байна.

XINYI SOLAR компанийн wuhu anhui мужын станц




М.Чинсанаа
Шинжээч


XINYI SOLAR компанийн beihai guanxi мужын станц



XINYI SOLAR компанийн борлуулалт задаргаа | 2021 эхний хагас



XINYI SOLAR компанийн нарны шилний технологи




XINYI SOLAR компанийг салбартай харьцуулбал

Үзүүлэлт	Xinyi Solar	Салбарын бусад компани
Нийт орлого	\$ 12.32 тэрбум	\$ 12.2 тэрбум
Борлуулалтын орлогын өсөлт /жилээр/	35%	9.90%
Бүтээгдэхүүний өртгийн дараах ашиг	\$ 6.58 тэрбум	\$ 2.56 тэрбум
Үйл ажиллагааны ашиг/ Орлого	53%	20%
Цэвэр ашиг	\$ 4.56 тэрбум	\$ 0.77 тэрбум
Цэвэр ашгийн харьцаа	37.00%	6%
ROE	22.40%	9.00%
Цэвэр мөнгөн урсгал	\$ 0.77 тэрбум	\$ -0.43 тэрбум
Ажилчдын тоо	5,079	6,705

БНХАУ-ын нарны эрчим хүчний 18 компани

1	Tongwei Co Ltd
2	JA Solar Technology Co Ltd
3	Xinyi Solar Holdings Ltd
4	Flat Glass Group Co Ltd
5	Daqo New Energy Corp
6	Risen Energy Co Ltd
7	GCL System Integration Technology Co Ltd
8	JinkoSolar Holdin Co Ltd
9	Shenzhen Topraysolar Co Ltd
10	Zhejiang Sunoren Solar Technology Co Ltd
11	EGing Photovoltaic Technology Co Ltd
12	Zhejiang Sunflower Great Health Limited Liability Company
13	IRICO Group New Energy Co Ltd
14	WG Tech JiangXi Co Ltd
15	Longitech Smart Energy Holding Ltd
16	Trina Solar Co Ltd
17	Arcotech Solar Holding Co Ltd
18	Xinjiang Daqo New Energy Co Ltd


Ашигт ажиллагааны харьцаа




Өр төлбөр барагдуулах чадвар



Хөшүүргийн харьцаа



Ашиг, өгөөж



Компанийн борлуулалт сүүлийн 5 жилд дунджаар 35 хувийн өсөлттэй байж 12.3 тэрбум хонконг долларт хүрээд байна. Харин үйл ажиллагааны орлого нь 56 хувьтай, цэвэр ашгийн маржин нь 39 хувьд хүрч 4.56 тэрбум хонконг долларт хүрчээ. Харин салбарын бусад компанийн борлуулалт 9.9 хувийн өсөлттэй байгаа бол цэвэр ашиг нь 6 хувь буюу 0.77 тэрбум ам.доллар болжээ. Мөн цэвэр мөнгөн урсгал нь нэмэгдэж буй цорын ганц компани юм.

Дүгнэлт

Дэлхийн хэмжээнд ирээдүйд шинээр бий болох цахилгаан эрчим хүчний хэрэглээний 99 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах бөгөөд үүний 70 хувийг нар болон салхины эрчим хүчнээс авахаар байна.

Тиймээс БНХАУ-ын сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн компаниудад хөрөнгө оруулалт хийх нь хамгийн тохиромжтой юм. Учир нь тус улсын нийт хэрэглээний 50-60 хувийг хангах хөрөнгө оруулалтын шийдлийг төсөвт суулгажээ.

Тэр дундаа БНХАУ-д нарны цахилгаан станцын чиглэлээр 35 хувийн борлуулалтын өсөлттэй, эерэг мөнгөн урсгалтай үйл ажиллагаа явуулж байгаа цорын ганц компани болох Xinyi Solar-т хөрөнгө оруулахуйц байна. Учир нь тус компанийн үнэлгээ ирэх жилүүдэд 20-50 хувиар өсөх боломжтой байгаа юм. Түүнчлэн сэргээгдэх эрчим хүчний салбарын ирээдүйг тооцвол БНХАУ-ын бусад 17 компанид ч хөрөнгө оруулах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД


Монгол Улсын эдийн засгийн өсөлт экспортоос хамаарна

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн идэвхжлийн нөлөөгөөр түүхий эдийн үнэ нэмэгдэж, улс дамнасан нийлүүлэлтийн сүлжээний доголдол, тээврийн зардлын өсөлт, эдийн засгийн сэргэлтээс улбаатай эрэлтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр олон улсад үнийн өсөлт эрчимжих хандлагатай байна.


Монгол Улсын хувьд 2020 онд эдийн засаг буурсан бол 2021 оны эхний хагас жилд 6.3 хувиар өсөв. Гэвч оны сүүлийн хагаст эдийн засгийн өсөлт удааширч 1.4 хувьд хүрлээ.

Тодруулбал, 2021 оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр байсан ч сүүлийн хагаст хөл хорио, хилийн хязгаарлалт, вирусын тархалтын улмаас эдийн засгийн бодит үйлдвэрлэл цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинд ирээд байна.

ДНБ, нэрлэсэн үнээр | их наяд төгрөг



Эдийн засгийн өсөлт | хувь



Дэлхийн эдийн засгийн сэргэлт, таваарын зах дээр түүхий эдийн эрэлт өссөн нь экспорт, төсвийн орлогод эерэгээр нөлөөлсөн. Тухайлбал, 2021 онд экспортын үнэ 34.6 хувиар, импортын үнэ 18.6 хувиар өссөн нь гадаад худалдааны нөхцөл 13.6 хувиар сайжрахад нөлөөлсөн байна.

Мөн экспортын голлох түүхий эд болох зэс, нүүрсний үнэ өссөн тул хилийн гацаа, тээвэрлэлтийн асуудал богино хугацаанд шийдвэрлэгдвэл эдийн засгийн өсөлт 2021 оноос өндөр байхаар хүлээгдэж байна.



Н.Данзандагва

Голомт Капитал

ҮЦК ХХК-ийн

Арилжааны

хэлтсийн


захирал

Монгол Улсын 2022 оны эдийн засгийн төлөв байдал нь Ковид 19 цар тахлын шинэ хувилбарт дасан зохицох, улс орнуудын нөхцөл байдал болон авах хариу арга хэмжээний үр дүн, БНХАУ-ын хилийн хязгаарлалт, мөн Орос-Украйн улсуудын хооронд үүсээд буй дайны нөхцөл байдал цаашид хэрхэн үргэлжлэх, уг зөрчилдөөнт байдал нь олон улсын таваарын зах зээлд хэрхэн нөлөөлөх зэргээс хамаарахаар байна.


Түүхий эдийн үнийн өсөлт экспорт, төсвийн орлогод эерэгээр нөлөөллөө.

Таваарын бүтээгдэхүүний (зэс, нүүрс) эрэлт нэмэгдэж, ханш нь өссөн ч хилийн нэвтрүүлэх чадамж, цар тахалтай холбоотой хоригийн улмаас экспортын биет хэмжээ хангалттай өсөхгүй байгаа нь уул уурхайн салбарын өсөлт, төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж байна.

Гадаад худалдаа | тэрбум ам.доллар




Гадаад худалдааны тэнцэл | тэрбум ам.доллар




Гадаад зах зээлд экспортын голлох нэрийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, эрэлт өссөн нь валютын орох урсгалыг нэмэгдэхэд нөлөөлснөөр 2021 онд гадаад валютын цэвэр орох урсгал өмнөх 5 жилийн дунджаас өндөр байлаа.

Өнгөрсөн 2021 оны эдийн засгийн өсөлтийг зэс, нүүрсний экспорт бүрдүүлсэн. Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхийн тулд манай улсын зүгээс түүхий эдийн, ялангуяа нүүрс болон зэсийн экспортын биет хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Коксжих нүүрсний үнийн таамаглал



Зэсийн үнийн таамаглал



Гадаад валютын орох урсгал өндөр байгаа нь валютын ханш тогтвортой байхад нөлөөлөв

ОУВС нь Монгол Улсад 98 сая ам.долларын зээлийг олгосон, мөнгөжсөн алтны нөөц нэмэгдсэн зэрэг нь албан нөөцийн өсөлтөд эерэгээр нөлөөлж, 2021 оны эцэст 4.3 тэрбум ам.долларт хүрэв. Энэ нь валютын төлбөртэй импортын 7 сарын хэрэгцээг хангах үзүүлэлт юм.


Монголбанкнаас цар тахлын хүндрэлийн үед валютын зах дээр үүсэж болзошгүй огцом савлагааны эсрэг арга хэмжээнүүдийг авсны үр дүнд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2021 оны туршид тогтвортой (хэлбэлзэлгүй) байж, 2020 оны эхнээс 0.02 хувиар чангараад байна.

Энэ нь манай улс зах зээлийн системд шилжсэнээс хойш буюу сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд дотоодын валютын зах зээл дэх хамгийн “Тогтвортой” үе болж байна.


Нөгөө талаас дэлхийн улс орнуудад цар тахлын эсрэг вакцинжуулалт эрчимтэй хийгдэж, тэргүүлэгч орнуудын эдийн засаг сэргэснээр манай улсын экспортын голлох түүхий эдийн үнэ өссөн нь эерэг нөлөө үзүүлэв.

Тухайлбал экспортын гол бүрэлдэхүүн болох зэс, нүүрс, төмрийн хүдрийн үнэ 2021 онд арваас дээш хувиар өссөн байна.

ГВАН, (тэрбум ам.доллар)⁴




Ам.долларын нэрлэсэн ханш




Цар тахлын үед төрөөс хэрэгжүүлж буй бодлого нь мөнгөний нийлүүлэлт, зээл олголтыг нэмж байна

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөлөөг хумих, макро эдийн засгийг идэвхжүүлэхээр төрөөс хэрэгжүүлсэн бодлогын (10 их наяд төгрөгийн хөтөлбөр, хөнгөлөлтүүд, иргэдэд бэлнээр тараасан мөнгө г.м) арга хэмжээ нь санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, иргэд, ААН-үүдийн үйл ажиллагаа, хэрэглээ, худалдан авалтыг өсгөх, банкны системийн зээл олголтыг нэмэгдүүлэх зорилготой байв. Энэ нь эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарахад нөлөөлсөн.

Нийт зээл | их наяд төгрөг



Мөнгөний нийлүүлэлт | их наяд төгрөг




Тухайлбал, 2020 онд нийт зээлийн үлдэгдэл өмнөх оныхоос 6.5 хувиар буурсан юм. Харин 2021 онд ЗГ-аас хэрэгжүүлсэн 10 их наядын цогц төлөвлөгөө нь эдийн засаг идэвхжих, зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлсөн.

Цар тахал, тээврийн гацалт үргэлжилбэл инфляци 2022 онд тасралтгүй өснө

Монголбанкны үзэж буйгаар цар тахлын тархалттай холбоотойгоор эдийн засгийн салбаруудын өсөлт жигд бус, богино болон дунд хугацааны төлөв тодорхой бус хэвээр байна.

Хэдийгээр төв банкнаас богино, дунд хугацаанд (2022-2024) инфляцыг 6 ± 2 нэгж хувийн интервалд хадгалах бодлогыг хэрэгжүүлж байгаа ч сүүлийн саруудад инфляц тасралтгүй өсч байна.

Инфляци | жилийн



Инфляци | бүлгүүдийн бүрдүүлж буй хувиар



Эх сурвалж: www.1212.mn

Жилийн инфляц 2021 оны 12 сард улсын хэмжээнд 13.4 хувьд хүрэв. Үүний 5.6 нэгж хувийг (41.8 хувь) хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлт, 2.8 нэгж хувийг (20.7 хувь) тээврийн бүлгийн үнийн өсөлт тус тус бүрдүүлэв.

2021 оны 4 сараас эхлэн суурь үнэ, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц өсч байгаа бөгөөд төв банкнаас 2022 оны сүүлийн хагаст зорилтод түвшинд тогтворжих хүлээлттэй байна.





Р.Дарханбаяр
Голомт
Капитал УЦК
ХХК-ийн Хөрөнгө
оруулалтын
шинжээч


ДЭЛХИЙД ЦАХИУР ХАГАЛСАН МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-2021 ОН

Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 5.97 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 97.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

2021 оны 9 дүгээр сард Монголын хөрөнгийн зах зээлийн ТОП-20 индекс 130 орчим хувийн өсөлттэйгөөр дэлхийн хамгийн өндөр өсөлттэй индексээр нэрлэгдсэн юм.


Үүнийг Блүүмберг агентлаг **“Дэлхийн хамгийн хүйтэн нийслэлд хамгийн халуухан хөрөнгийн зах байна”** гэж онцолсон.

Хөрөнгийн зах зээлийн индексийн өсөлт



Эх сурвалж: Investing.com

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ | ДНБ%



Эх сурвалж: Дэлхийн банк, УСК

Хэдийгээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нэмэгдэж, арилжааны идэвх өссөн ч Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил бусад орнуудаас сул хэвээр байна.

Тухайлбал, 2020 онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ий 8.1 хувийг эзэлж байсан бол 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ДНБ-ий 17.5 хувийг бүрдүүлж байна.

2011 онд Монголын хөрөнгийн зах зээл нь уул уурхайн салбарын өсөлт, эдийн засгийн идэвхжил, гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр ДНБ-ийн 16.5 хувьтай тэнцэж байсан бол үүнээс хойш 2021 оныг дуустал тасралтгүй буурсан түүхтэй. Харин 2017 онд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүнүүд гарч, хөрөнгө оруулагчдын эрэлт нэмэгдсэнээр хөрөнгийн зах зээл эргэн идэвхжиж эхэлсэн юм.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨСӨЛТӨД ЮУ НӨЛӨӨЛӨВ?

Хадгаламжийн бодит өгөөж буурлаа

2021 онд харилцах дансанд тооцох хүү 0 хувь, бодлогын хүү 6 хувь болж буурсан. 2022 оны 1 сарын байдлаар арилжааны банкнуудын шинээр татсан жигнэсэн дундаж төгрөгийн хадгаламжийн хүү 7.3 хувь, инфляцын түвшин 14.6 хувь буюу хадгаламжийн бодит өгөөж -7.3 хувьтай байна.

Өөрөөр хэлбэл, төгрөгийн худалдан авах чадвар хадгаламжийн хүүнээс хурдацтайгаар буурч буй нь төгрөгийн хадгаламж иргэдэд өгөөжгүй болоход нөлөөлөв.

Хадгаламжийн хүү ба Инфляц



Банкнуудын хадгаламж | Их наяд төгрөг


	2020	2021	Өөрчлөлт %
	7,6	7,0	-7.50%
	4,0	3,9	-3.30%
	3,8	3,6	-6.20%
	2,3	2,2	-6.20%
	1,6	1,8	9.90%

Эх сурвалж: Банкнуудын вэбсайт,
Аудитлагдсан тайлан

Хувьцааны арилжаа нэмэгдлээ

Хадгаламжийн өгөөж буурснаар хувьцааны арилжаа идэвхжлээ. Тухайлбал 2011 оны 9 болон 11 сард хувьцааны өдрийн дундаж арилжаа огцом өссөнөөр 12 сарын байдлаар 2514.1 сая төгрөгт хүрэв.

Өдрийн дундаж арилжаа | сая төгрөг



Эх сурвалж: МХБ

2020 онд МХБ-ийн өдрийн дундаж арилжаа 210 орчим сая төгрөг байсан бол 2021 онд арилжааны идэвх өмнөх оноос 2-8 дахин нэмэгдсэн. Тодруулбал, хувьцааны арилжаа 2021 онд 53.8 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 0.15 хувьтай тэнцэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ




1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржээр дамжуулан гаргах анхны зөвшөөрлийг Инвескор Актив ТЗК ХХК-д олгов.



2. Мандал Ирээдүйн Өсөлт хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулагдаж 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэв.



3. Эрдэнэс Тавантолгой ХК нь Монголын хамгийн өндөр дүнтэй 2 их наяд төгрөгийн нээлттэй бондыг гаргав.



4. Үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчныг сайжруулж, үнэт цаасны бүртгэлийн журам, компанийн өрийн хэрэгслийн журам, Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталснаар хууль эрх зүйн орчин сайжрав.



5. Инвескор ББСБ 20 тэрбум төгрөг, ЛэндМН ББСБ 5 тэрбум, Монпэй 1 тэрбум төгрөгийн нээлттэй бонд гаргаснаар нээлттэй бондын зах зээл сэргэв.



6. Биржийн бус зах зээлийн анхны бондыг Голомт Капитал ҮЦК ХХК гаргав.



7. Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Степ Гоулд Лимитед компанийн давхар бүртгэлийн зөвшөөрлийг олгов.



8. Эрдэнэ Ресурс Девелопмент ХК нэмж хувьцаа гаргав.



9. 2021 онд МХБ дээр нийт 9 шинэ бүтээгдэхүүний хувьцаа, бонд гаргасан бөгөөд бүгд 100 хувь биелсэн бол "CU" хувьцаа 161 хувиар биелсэн нь онцлох татан төвлөрүүлэлт болов.



10. Богд банк анхны нээлттэй хувьцаат банк болж нийт 31.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээ.



11. Монголын хөрөнгийн зах зээл FTSE RUSSELL группийн "Ажиглалтын жагсаалт"-д орлоо.

2022 ОНЫ ОНЦЛОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БОЛОМЖИЙГ БҮҮ АЛД

2021 оны 12 сарын байдлаар МХБ-д нийт 1,414.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн. Үүний 74 хувийг буюу 1,048.2 тэрбум төгрөгийг бондын арилжаа эзэлж байна.

Бондыг хувьцаатай харьцуулахад эрсдэл багатай, зах зээлийн нөхцөл байдал болон компанийн ашиг, орлогоос хамааран үнэлгээ нь хэлбэлздэггүй бөгөөд анх тогтоосон хугацаа болон хүүний тогтсон ашгийг өгдөг. Нөгөө талаас, компаниуд богино хугацаанд уян хатан нөхцөлтэй бонд гаргаж, урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэртэй болох давуу талтай юм.

Жишээ нь, 2021 онд Голомт Капитал ҮЦК ХХК нь биржийн бус зах зээлийн анхны бонд болох Монкон бондын хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлсэн.

Тус бонд нь ХААН банкны баталгаатай, жилийн 13 хувийн хүүтэй, хувьцаа болон Монголын хамгийн том бүтээн байгуулалтын төслийн орлого барьцаалсан 14.5-15 хувийн хүүтэй бондоос тус тус бүрдсэн юм.

Улмаар хөрөнгө оруулагчдад эрсдэл болон зорилтод өгөөжийн түвшнээс хамаарсан олон төрөлт хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг санал болгож, хөрөнгө оруулагчид хадгаламжийн хүүнээс 1.5-2.0 дахин өндөр өгөөжийг хүртэх боломжийг олгосон билээ.

Голомт Капитал ҮЦК ХХК нь сүүлийн 6 сарын хугацаанд нийт 33.2 тэрбум төгрөгийн 7 төрлийн бондыг Биржийн бус зах зээлээр дамжуулан амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд хөрөнгө оруулагчдад нийт 1.2 тэрбум төгрөгийн хүүг амжилттай төлсөн байна.

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК-ИЙН СҮҮЛИЙН 6 САРД ГАРГАСАН БОНДУУД



МОНКОН БОНД
15 тэрбум төгрөг

Монголын анхны биржийн бус зах зээлийн бонд болох Монкон бонд



НӨМӨР БОНД
2 тэрбум төгрөг

Биржийн бус зах зээлийн бонд



БЭРС БОНД
10 тэрбум төгрөг

Монголын анхны шаталсан хүүтэй бонд болох Бэрс бонд



ТАЗ БОНД
4 тэрбум төгрөг

10 тэрбум төгрөгийн бондын хөтөлбөр



ГЭРЭГЭ БОНД
2.4 тэрбум төгрөг




Р.Дарханбаяр
Голомт
Капитал ҮЦК
ХХК-ийн Хөрөнгө
оруулалтын
шинжээч

ВАЛЮТЫН ХАДГАЛАМЖАА БОНД РУУ ХӨРВҮҮЛЖ ӨГӨӨЖ ХҮРТЭХ БОЛОМЖ

Монголын банкны салбар дахь валютын хадгаламжийн хүү буурсан, ам.доллар төгрөгийн эсрэг тогтвортой, валютын зах зээлийн суурь үзүүлэлтүүд сайн байгаа нь цаашид ам.долларын ханш төгрөгийн эсрэг огцом хэлбэлзэхгүй байх суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Мөн 2021 оны 12 сарын байдлаар валютын хадгаламжийн дундаж хүү 3.4 хувь байгаа нь сүүлийн 4 жилийн дунджаас 0.6 хувиар бага үзүүлэлт болоод байна. Валютын хадгаламжийн хүү бага байгаагаас гадна ам.долларын ханшийн хэлбэлзэл хэвийн түвшинд байх хүлээлттэй байгаа тул өндөр хүүтэй төгрөгийн бондууд болон ам.долларын бондуудад хөрөнгө оруулах нь хөрөнгө оруулалтын бодит өгөөжийг нэмэгдүүлэхээр байна.

Валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Монголбанк

ХӨРӨНГИЙН ШИНЭ СОЁЛ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС

Цаашид хөрөнгийн зах зээлд хөгжих ирээдүйтэй шинэлэг бүтээгдэхүүн бол хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Бондтой харьцуулахад эргэн төлөгдөх мөнгөн урсгал нь үе шаттай тул хөрвөх чадвар илүү сайн байдаг.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь компанийн дампуурлаас ангид тул үйл ажиллагаанаас нь шалтгаалах эрсдэл багатай.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ард буй хөрөнгийн багц нь ихэвчлэн тараан байршсан олон хөрөнгөнөөс бүрддэг. Тиймээс нэг төрлийн хөрөнгөөс хамаарах эрсдэлийг бууруулдаг давуу талтай юм.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг банк, банк бус санхүүгийн байгууллага болон ирээдүйн тогтмол мөнгөн урсгалаар баталгаажсан хөрөнгийн багцтай компаниуд гаргадаг.

Энэ нь хөрөнгө оруулагчдад өөрсдийн мөнгийг хадгаламжаас өндөр хүүтэйгээр өсгөх, компаниудад өртөг багатай санхүүжилт татах боломжийг нээдэг.

ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ ДАВАЛГАА ҮҮСЛЭЭ

2020 онд Ковид 19 цар тахлын нөлөөгөөр үүссэн эдийн засгийн хямрал нь дотоодын аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн. Харин эдийн засгийн шоконд өртөх магадлал багатай, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний салбар болон санхүүгийн салбарын хувьцаа өсөлттэй байлаа.

Тодруулбал, 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар дотоодын онцлох компаниуд болон Голомт Капитал ҮЦК ХХК-ийн андеррайтераар нь ажилласан Түмэн Шувуут, Монос Хүнс, Мандал Даатгал хувьцаат компаниудын санхүүгийн бөгөөд үйл ажиллагааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:



Б.Тэлмэн
Голомт
Капитал ҮЦК
ХХК-ийн Хөрөнгө
оруулалтын
шинжээч

Хувьцааны арилжааны мэдээлэл

02-р сарын 21, 2021	MSE:MFC
Хаалтын ханш (2022.02.21):	139.18₮
52 долоо хоног:	135.00₮ - 141.96₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	408,850,428
Зах зээлийн үнэлгээ:	₮56,903,802,569.04

Хувьцааны арилжааны түүх




Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд

Үнэ-ашигийн харьцаа (P/E)	22.8
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	3.8
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	3
Ногдол ашгийн өгөөж	1.40%


Тодруулга: Хувьцааны ханшийг 2022/02/21-өөр, санхүүгийн үзүүлэлтийг 2021 оны 4-р улирлын тайлангаар, Ногдол ашгийн өгөөжийг 2022 онд тараах ногдол ашигт үндэслэн тооцов.

Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК тооцоолол


Хувьцаа эзэмшигчид



Борлуулалтын орлого
| сая төгрөг
2017-2021
(CARF 33%)



Цэвэр ашиг
| сая төгрөг
2017-2021
(CARF 38%)



КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Монос группийн охин компаниудын нэг Монос Хүнс ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд эрүүл мэндийг дэмжигч хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус компани нь эрүүл мэндийн бэлдмэл, үрлэн чихэр, цай, цэвэр ус, жимсний шүүс гэсэн хүнсний бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлдэг бөгөөд Монгол Улсын 21 аймгийн 7,000 гаруй цэгт бүтээгдэхүүнээ борлуулж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Монос Группийн үүсгэн байгуулагч нь Л.Хүрэлбаатар бөгөөд Монос Хүнс ХК-ийн 70 хувийг эзэмшдэг. Компанийн 30 хувийг олон нийтэд санал болгосон ба нийт 408,850,428 хувьцааг хөрөнгийн зах дээр арилжаалж байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монос Хүнс ХК нь 180 гаруй ажилтантай, нийт 13 брэндийн 83 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Монос Хүнс ХК-ийн бүтээгдэхүүн нь Эм судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаанд үндэслэн олон улсын стандартын дагуу бүтээгдэж, оюуны өмчөөр баталгаажсан. Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор дотоодын зах зээлд эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүнүүдийн эрэлт өндөр байна.


COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД

Компани нь нийт ажилтнуудаа дархлаажуулалтад бүрэн хамруулж, Ковидын эрсдэлээс хамгаалах даатгалд бүрэн хамруулсан байна. Улмаар цар тахлын хүнд үед ч эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрийн төслийг тасралтгүй үргэлжлүүлж ажлын байраа 30 гаруй хувиар нэмэгдүүлснээр шингэн хүнсний борлуулалт 2.3 дахин нэмэгдсэн байна.


САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2021 оны 3 дугаар улирлын байдлаар борлуулалтын орлого 13 тэрбум төгрөгт, цэвэр ашиг 1.3 тэрбум төгрөгт, нийт хөрөнгө 20.7 тэрбум төгрөгт тус тус хүрсэн. 2017-2020 оны хооронд компанийн нийт хөрөнгө жилд дунджаар 38 хувиар, борлуулалтын орлого 28 хувиар, цэвэр ашиг 22 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Борлуулалтын орлого өсөхөд дархлаа дэмжих бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон VITA 500, SHOT зэрэг шинэ бүтээгдэхүүний борлуулалт нөлөөлсөн байна. 2022.01.20-ны байдлаарх компанийн хувьцааны ханшийг 2021 оны эхэн үетэй харьцуулахад 72 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.


Нийт хөрөнгө
| сая төгрөг
2017-2021
(CARF 33%)



Хөрөнгийн бүтэц
● Эргэлтийн хөрөнгө
● Эргэлтийн бус хөрөнгө



Санхүүжилтийн бүтэц
● Эздийн өмч
● Өр төлбөр



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

Хувцааны арилжааны мэдээлэл

02-р сарын 21, 2021	MSE:TUM
Хаалтын ханш (2022.02.21):	620₮
52 долоо хоног:	208₮ - 816₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	200,000,000
Зах зээлийн үнэлгээ:	₮124,096,000,000

Хувьцааны арилжааны түүх




Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд

Үнэ-ашгийн харьцаа (P/E)	17.9
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	3.9
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	3.5
Ногдол ашгийн өгөөж	1.7%

Тодруулга: Хувьцааны ханшийг 2022/02/21-өөр, санхүүгийн үзүүлэлтийг 2021 оны 4-р улирлын тайлангаар, Ногдол ашгийн өгөөжийг 2022 онд тараах ногдол ашигт үндэслэн тооцов.


Эх сурвалж: Голомт Капитал ҮЦК тооцоолол

Хувьцаа эзэмшигчид




Эх сурвалж: МХБ


Борлуулалтын орлого
| сая төгрөг
2017-2021
(CARF 29%)



Цэвэр ашиг
| сая төгрөг
2017-2021
(CARF 49%)




Нийт хөрөнгө
| сая төгрөг
2017-2021
(CARF 36%)




Хөрөнгийн бүтэц

● Эргэлтийн хөрөнгө
● Эргэлтийн бус хөрөнгө



Санхүүжилтийн бүтэц

● Эздийн өмч
● Өр төлбөр



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал ҮЦК тооцоолол

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Түмэн Шувуут ХК нь 2004 онд 20,000 өндөглөгч тахитайгаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд салбартаа тэргүүлэгч компани юм. Тус компани нь хөдөө аж ахуйн цогц шийдэл болох малын тэжээлийн үйлдвэр, өндөгний сав баглааны үйлдвэр, органик бордооны үйлдвэр, усалгаатай газар тариаланг хөгжүүлж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Түмэн Шувуут ХК-ийн 30 хувийг үүсгэн байгуулагч Л.Эрхэмбаяр, ТУЗ-ийн гишүүн Б.Тунгалаг тус тус эзэмшдэг бол Гүйцэтгэх захирал Ж.Болд, Гадаад харилцаа хариуцсан захирал Э.Баяржаргал нар тус бүр 10 хувийг эзэмшдэг. Компани нь 20 хувиа олон нийтэд санал болгосон ба нийт 200 сая ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээл дээр арилжаалж байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компани нь нийт 350 мянган өндөглөгч тахитай, 200 гаруй ажилтантайгаар Монгол Улсын дотоодын нийт өндөгний үйлдвэрлэлийн 30 гаруй хувийг ханган ажилладаг. Түмэн Шувуут ХК-ийн борлуулалтын орлогын 80 гаруй хувийг өндөгний борлуулалт бүрдүүлдэг ба 2021 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 60 сая ширхэг өндөг үйлдвэрлэжээ. Тус компани өндөгний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх зорилгоор ТҮМЭН ШУВУУТ-2 төслийг хэрэгжүүлж, 2024 он гэхэд 7 өндөглөгчийн байр, 1 дэгдээхийний байр нэмж барихаар ажиллаж байна.

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД

Компани нь халдвар хамгааллын дэглэмийг чанд сахин, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тус компани нь цар тахлын үер ажилчдаа цомтгохгүй, цалин хөлсөд нь өөрчлөлт оруулахгүй байх бодлогыг баримтлан ажилласан.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2021 оны 3 дугаар улирлын байдлаар 27.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан бөгөөд 5.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 96 хувийн өсөлт юм. Компанийн санхүүжилтийн бүтцийн хувьд хувьцаагаа олон нийтэд санал болгосноос хойш өр төлбөрийн хэмжээ буурч, тайлант үеийн байдлаар санхүүжилтийн эх үүсвэрийн 23 хувийг өр төлбөр, 77 хувийг эздийн өмч бүрдүүлж байна. 2022.01.20-ны байдлаарх компанийн хувьцааны ханшийг 2021 оны эхэн үетэй харьцуулахад 286 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

APU COMPANYY

Absolute. Pure. Unique.

Хувьцааны арилжааны мэдээлэл

02-р сарын 21, 2021	MSE:APU
Хаалтын ханш (2022.02.21):	1,697₮
52 долоо хоног:	705₮ - 1,904₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	1,064,181,533
Зах зээлийн үнэлгээ:	₮1,803,868,138,871

Хувьцааны арилжааны түүх



Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд

Үнэ-ашигын харьцаа (P/E)	11.6
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	3.7
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	3.2
Ногдол ашгийн өгөөж	6.1%

Тодруулга: Хувьцааны ханшийг 2022/02/21-өөр, санхүүгийн үзүүлэлтийг 2021 оны 3-р улирлын тайлангаар, Ногдол ашгийн өгөөжийг 2021 онд тараасан ногдол ашигт үндэслэн тооцов.

Эх сурвалж: Голomt Капитал ҮЦК тооцоолол

Хувьцаа эзэмшигчид



КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК нь 1924 оноос шингэн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаагаа тууштай явуулж буй Монголын ууган үйлдвэрлэгч компани юм. Тус компани Чех улсын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1927 онд шар айраг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд АПУ ХК нь согтууруулах ундааны болон шар айргийн зах зээлд дотооддоо тэргүүлэх байр суурьтай нийт 8 охин компани, 1 хараат компанитай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

АПУ ХК-ийн 56.09 хувийг Шунхлай Групп, 25.03 хувийг Heineken Asia Pacific PTE LTD, 13.36 хувийг Steppe Beverage KFT тус тус эзэмшдэг. Компани нь 5.42 хувийг олон нийтэд санал болгосон ба нийт 1,064,181,533 тоо ширхэг хувьцааг хөрөнгийн зах зээл дээр арилжаалж байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

АПУ ХК нь нийт 2060 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж, 319 нэр төрлийн бүтээгдэхүүнийг дотоодын болон гадаадын зах зээлд борлуулдаг. Компани нь 2021 онд сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувийн жингээ нэмэгдүүлэх стратеги баримтлан ажиллаж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлсэн. 2021 онд согтууруулах төрлийн ундааны сав баглааг шинэчилснээс гадна анх удаа спиртгүй шар айргийг зах зээлд нийлүүлсэн.

COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД

Компани нь Ковид 19 цар тахлын үеийн менежментийн бодлогыг амжилттай хэрэгжүүлж, тэвчиж болох зардлуудыг танасан нь ашигт ажиллагаанд нь тодорхой нөлөөлөөг үзүүлсэн байна. Цар тахлын үед бизнесийн эрсдэл нэмэгдсэн бөгөөд эрсдэлээс хамгаалахын тулд компанийн зээл болон авлагад өндөр хяналт тавин ажиллаж байна.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ


2021 оны 3 дугаар улирлын байдлаар АПУ ХК-ийн борлуулалтын орлого 415 төгрөгт, цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 42 хувиар өсөж 117.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэхүү орлогын өсөлтөд шар айраг, ус, ундаа, сүүн бүтээгдэхүүний борлуулалтын өсөлт нөлөөлжээ. 2017-2020 оны хооронд компанийн нийт борлуулалтын орлого 28 хувиар, цэвэр ашиг 53 хувиар тус тус өссөн бол нийт хөрөнгийн хэмжээ 4 хувийн бууралтыг үзүүлсэн байна. 2022.01.20-ны байдлаарх хувьцааны ханшийг 2021 оны эхэн үетэй харьцуулахад 177 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

Борлуулалтын орлого

| тэрбум төгрөг

2017-2020

(CARG 20.4%)




Цэвэр ашиг

| тэрбум төгрөг

2017-2020

(CARG 38.8%)




Нийт хөрөнгө

| тэрбум төгрөг

2017-2020

(CARG 0.7%)




Хөрөнгийн бүтэц

● Эргэлтийн хөрөнгө

● Эргэлтийн бус хөрөнгө

2019 2020 2021




Санхүүжилтийн бүтэц

● Эздийн өмч

● Өр төлбөр

2019 2020 2021



Эх сурвалж: МХБ, Голomt Капитал ҮЦК тооцоолол

Хувьцааны арилжааны мэдээлэл

02-р сарын 21, 2021	MSE:MNDL
Хаалтын ханш (2022.02.21):	1,697₮
52 долоо хоног:	705₮ - 1,904₮
Нийт хувьцааны тоо ширхэг:	1,064,181,553
Зах зээлийн үнэлгээ:	₮1,803,868,138,871

Хувьцааны арилжааны түүх




Хүснэгт 2. Харьцаа үзүүлэлтүүд

Үнэ-ашгийн харьцаа (P/E)	11.6
Үнэ-дансны үнийн харьцаа (P/B)	3.7
Үнэ-хувьцааны харьцаа (P/S)	3.2
Ногдол ашгийн өгөөж	6.1%


Тодруулга: Хувьцааны ханшийг 2022/02/21-өөр, санхүүгийн үзүүлэлтийг 2021 оны 3-р улирлын тайлангаар, Ногдол ашгийн өгөөжийг 2021 онд тараасан ногдол ашигт үндэслэн тооцов.

Эх сурвалж: Голомт Капитал УЦК тооцоолол


Хувьцаа эзэмшигчид




Борлуулалтын орлого | тэрбум төгрөг 2017-2021 (CARF -5%)




Цэвэр ашиг | тэрбум төгрөг 2017-2021 (CARF 50%)



Нийт хөрөнгө | тэрбум төгрөг 2017-2021 (CARF 29%)



Санхүүжилтийн бүтэц



Эх сурвалж: МХБ, Голомт Капитал УЦК тооцоолол

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ

Мандал Даатгал ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд даатгалын салбарт суурь систем нэвтрүүлсэн салбартаа тэргүүлэгч компани юм. 2021 онд олон улсын санхүүгийн зэрэглэл тогтоодог AM Best агентлагаас компанийн санхүүгийн ерөнхий чадавхийг "B", урт хугацааны эзэлжих зэрэглэлийг "BB+" буюу цаашдын төлөвийг "Тогтвортой" гэх үнэлгээг өгч баалгаажуулсан байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Мандал Даатгал ХК нь 2018 онд компанийн 25 хувийг олон нийтэд санал болгон нээлттэй компани болсон. Эдүгээ тус компанийн 40.9 хувийг Голомт Файнэншил Групп ХХК, 37.3 хувийг Юу Эм Си Капитал ХХК тус тус эзэмшиж байна.

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мандал Даатгал ХК нь нийт 120 гаруй ажилтантай бөгөөд иргэдийн болон байгууллагын гэсэн үндсэн 2 чиглэлд 22 хэлбэрийн эрсдэлийг даатгах 52 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг 78 мянга гаруй даатгуулагчдад санал болгон ажиллаж байна. Компани нь салбартаа тэргүүлэгч бөгөөд өөрсдийн дааж чадах хэмжээнээс давсан томоохон эрсдэлүүдийг "AM Best" агентлагаас "A+" үнэлгээг авсан SCOR болон Hannover Re зэрэг дэлхийн шилдэг давхар даатгалын компаниудаар даатгуулдаг байна.

COVID-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД

Ковид-19 цар тахлын үед Мандал Даатгал ХК нь зах зээлд эзлэх байр сууриа хадгалах бодлогыг баримталж, эдийн засгийн нөхцөл байдал сайжрах үед байр сууриа тэлэх зорилго тавин ажиллаж байна. Компанийн зүгээс зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Ковид-19 даатгалын бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлсэн юм.

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

2021 оны 3 дугаар улирлын байдлаар Мандал Даатгал ХК-ийн нийт хураамжийн орлого 29.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хувиар өссөн. Харин цэвэр ашгийн хэмжээ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 4.5 тэрбум төгрөгт хүржээ. 2017-2020 оны хооронд компанийн нийт хөрөнгийн хэмжээ жил дунджаар 37 хувиар, нийт хураамжийн орлогын хэмжээ 14 хувиар, цэвэр ашгийн хэмжээ 60 хувиар тус тус өссөн. 2022.01.20-ны байдлаарх компанийн хувьцааны ханшийг 2021 оны эхэн үетэй харьцуулахад 131 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.



Б.Тэлмэн
Голомт
Капитал УЦК
ХХК-ийн Хөрөнгө
оруулалтын
шинжээч



Б.Буяаннэмэх

Голомт
Капитал ҮЦК
ХХК-ийн Хөрөнгө
оруулалтын
шинжээч

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС БАНКНЫ ЭЗЭН БОЛОХОД 3 САР ҮЛДЛЭЭ

Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжил нь өнөөг хүртэл банк төвтэй байв. УИХ-аас 2021 оны 1 сарын 29-нд Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар олон тулгуурт санхүүгийн зах зээлийн хөгжлийн үндэс тавигдаад байна.



Тус хуулийн дагуу системийн нөлөө бүхий 5 банк 2022 оны 6 сарын 30-ны дотор нээлттэй хувьцаат компани болж, олон нийтэд хувьцаагаа санал болгох (IPO), 2023 оны 12 сарын 31-ний дотор нэг хувьцаа эзэмшигчид ногдох эзэмшил 20 хувиас ихгүй байхаар хуульчилсан юм.



Мөн банкны реформ хийгдсэнээр харилцагч зөвхөн банкинд мөнгөө хадгалуулах бус хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэнэ. Ингэснээр банкнаас хэт их хамааралтай санхүүгийн зах зээлийг задалж, хөрөнгийн зах зээл хөгжих нөхцөл бүрдэх юм.




Түүнчлэн, тэтгэврийн сан, хөрөнгө оруулалтын сан зэрэг мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагчдын орон зай нэмэгдэнэ. Олон улсад топ банкнуудын голлох хувьцаа эзэмшигчид нь мэргэжлийн институциональ хөрөнгө оруулагчид байдаг. Жишээлбэл, 2021 оны байдлаар дэлхийн топ банкууд болох JP Morgan Chase&Co, Goldman Sachs, Wells Fargo банкнуудын хамгийн том хувьцаа эзэмшигчид нь Vanguard, SSgA, Blackrock зэрэг хөрөнгө оруулалтын сангууд юм.


Банкны системийн нөлөө бүхий 5 банк

2021 оны 4 дүгээр улирлын байдлаар системийн нөлөө бүхий 5 банк буюу Хаан, Худалдаа Хөгжлийн банк, Голомт, Төрийн банк, Хас банкнуудын нийт актив 38.3 их наяд төгрөгт хүрч, банкны салбарын 93 хувийг бүрдүүлж байна.

Нийт хөрөнгө | тэрбум төгрөг



Өөрийн хөрөнгө | тэрбум төгрөг



Эх сурвалж: Банкуудын вебсайт

ОНЦЛОХ БАНК: ГОЛОМТ БАНК

Голомт банк

Голомт банк нь 1990 оны 3 сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Өдгөө тус банк нь орон даяар 104 салбар нэгжтэй бөгөөд 2,400 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус банк нь байгуулагдсан цагаасаа эхлэн иргэд болон байгууллагын зах зээлд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг хослуулан үзүүлсээр ирсэн. Голомт банкны онцлог давуу талаас дурьдвал:

Байгууллагын зах зээлд тэргүүлэгч

Голомт банк нь байгууллагын зах зээлд санхүүгийн цогц шийдлийг агуулсан бүтээгдэхүүнийг санал болгодог шилдэг байгууллагын банк юм. Тодруулбал, байгууллагын харилцагчийн бизнес санааг цаасан дээр байхаас нь амжилттай хэрэгжиж, үр дүнгээ өгөх хүртэлх шаардлагатай зөвлөгөө мэдээллээр тогтмол хангах, санхүүжилт олгох, болзошгүй эрсдэлийг бууруулах шийдлийг хэрэгжүүлэх зэргээр бүх шатны санхүүгийн зөвлөх үйлчилгээг үзүүлдэг нь харилцагчдад өгч буй хамгийн том үнэ цэн юм.



2021 онд Олон улсын банк санхүүгийн салбарт нэр хүнд бүхий сэтгүүл болох Global Banking & Finance Review-с Голомт банкыг Монгол улсын шилдэг байгууллагын банкаар тодруулсан.

Инновацаар тэргүүлэгч Шилдэг дижитал банк

Голомт банк нь Монголын банк санхүүгийн салбарт технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмын шинэчлэлт, хөгжүүлэлтийг тогтмол нэвтрүүлж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлийг бий болгож, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг анхлан нэвтрүүлж ирсэн Монгол Улсын шилдэг дижитал банк юм.

Голомт банк нь дижитал банкны үйлчилгээгээр салбартаа тэргүүлж Олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудаас дараах шагналуудыг хүртсэн байна.

- Олон улсын банк санхүүгийн салбарын нэр хүндийг тодорхойлогч Global Finance сэтгүүлээс Голомт банкыг Монгол Улсын Шилдэг Дижитал банк - 2011, 2013, 2014, 2015, 2019, 2020, 2021 он
- Олон улсын AmChamRepresent Awards apra хэмжээний Digital Transformation (MNC) төрөлд технологийн шинэчлэл, дижитал шилжилтээр шилдэг банк,- 2021 он
- Infosys Client Innovation Award-2020 apra хэмжээний Modern Technologies Led innovation төрөлд Дижитал банк 5.0 болон UFC системээр шилдэг банк "COVID Response Innovation" төрөлд SocialPay дижитал хэтэвч болон Робот процесс автоматжуулалтын системээр шилдэг банк – 2019, 2020, 2021 он




ГОЛОМТ БАНК

Голомт банк нь 1990 оны 3 сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Эдүгээ тус банк нь орон даяар 104 салбар нэгжтэй бөгөөд 2,400 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

ГОЛОМТ БАНКНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД | тэрбум төгрөгөөр


Хүүгийн цэвэр орлого

2020-2021 өсөлт: 20.2%




Татварын дараах ашиг, алдагдал

2020-2021 өсөлт: 112.6%




Зээл | цэвэр дүнгээр

2020-2021 өсөлт: 7.6%




Нийт хөрөнгө

2020-2021 өсөлт: 8.6%




Харилцах

2020-2021 өсөлт: 22.2%



Хадгаламж

2020-2021 өсөлт: -7.1%



Эх сурвалж: Голомт банкны аудитлагдсан жилийн тайлан, аудитлагдаагүй 2021 оны 4-р улирлын тайлан

БИД ТАНД ЮУ ӨГЧ ЧАДАХ ВЭ?

Голомт Капитал ҮЦК ХХК нь харилцагчдадаа хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргахад нь мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, үнэн, зөв мэдээллээр хангах зорилготой мэдээлэл судалгааг цаг алдалгүй хүргэж байна.

Тодруулбал, дэлхийн болон дотоодын зах зээл, онцлох салбар, компаниудын талаарх судалгааг харилцагчдадаа хүргэхийн тулд онлайн уулзалтыг зохион байгуулахаас гадна биечлэн зөвлөгөө өгч, цахим хуудсаараа тогтмол мэдээлж байна.


Мөн харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлэх зорилгоор анхан, дунд, ахисан түвшний сургалтыг тогтмол зохион байгуулж ирлээ.

БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь харилцагчдадаа тив дэлхийн хаана ч байсан хүссэн үедээ Монголын болоод дэлхийн хөрөнгийн биржүүдийн арилжаанд оролцох, өөрийн хөрөнгийг амжилттай удирдахад нь үнэнч туслагч нь байж ирсэн төдийгүй цаг үеийн мэдээ мэдээлэл, судалгаа шинжилгээг тогтмол хүргэн ажиллаж байна.

ДОТООДЫН ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь харилцагчдадаа <http://trader.golomtcapital.com/> онлайн арилжааны систем, Golomt Capital аппликэйшн, SocialPay аппликэйшнийг ашиглан тив дэлхийн хаанаас ч хүссэн үедээ хөрөнгө оруулалт хийх, мөнгө татах, мэдээлэл, судалгаатай танилцах, ханш харах, өөрийн хөрөнгө оруулалтын багц, өгөөж ашгийн тооцооллыг харах боломжийг олгодог.



Хөрөнгө оруулах боломжтой бүтээгдэхүүн

- Хувьцааны анхдагч болон хоёрдогч арилжаа
- Компанийн нээлттэй болон хаалттай бонд
- Засгийн газрийн бонд
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

Мөн бид таны эзэмшиж буй үнэт цаасыг шилжүүлэх, бусдад бэлэглэх, гэрээслэх, итгэмжлэх болон өв залгамжлах зэрэг нэмэлт үйлчилгээг үзүүлнэ.

Та арилжаанд оролцохоосоо өмнө хамгийн чухал алхам болох судалгаа, шинжилгээ, мэдээлэлтэй танилцан шийдвэрээ гаргаарай. Бид таныг оновчтой шийдвэр гаргахад тань үргэлж хамт байж туслах болно.

ГАДААДЫН ҮНЭТ ЦААСНЫ БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь Монгол Улсад анх удаа буюу 2014 онд Хонгконгт төвтэй гадаад арилжааны брокерын үйлчилгээг, 2019 онд АНУ-д төвтэй Interactive Brokers онлайн брокерийн үйлчилгээг албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлсэн билээ.

Ингэснээр харилцагч Interactive Brokers платформоор дамжуулан хүссэн үедээ дэлхийн хөрөнгийн биржүүдийн арилжаанд онлайнаар оролцон хөрөнгө оруулах боломжтой болсон юм.

Тухайлбал, харилцагчид Хонгконгийн биржид IPO хийж буй компаниудын анхдагч зах зээлийн арилжаанд оролцон хамгийн хямд үнээр хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон билээ.

Харилцагч та Interactive Brokers үйлчилгээгээр дамжуулан 135 биржийн 23 улсын валютаар 600 гаруй төрлийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ авах боломжтой.



Арилжаанд оролцох боломжтой биржүүд:

- NYSE, NASDAQ
- HKEX, SSE
- TSE, TMX
- Бусад олон улсын биржүүд

Хөрөнгө оруулах боломжтой бүтээгдэхүүн:

- Хувьцаа | анхдагч, хоёрдогч арилжаа
- Бонд
- Үүсмэл үнэт цаас | option, warrant
- ETF | биржээр арилжаалагддаг сан
- Валютын арилжаа

Interactive Brokers нь 1977 онд байгуулагдсан ба дэлхий даяар автоматжуулсан цахим зуучлал, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг. АНУ, Швейцарь, Канад, Хон Конг, Их Британи, Австрали, зэрэг улсуудад салбар төвүүдтэй ба 1850 гаруй ажилтантай, 981 мянга гаруй харилцагчтай.

- 2019 оны шилдэг онлайн брокер
- Олон улсын мэргэжлийн арилжаачдын №1 үнэлгээтэй
- Олон улсын идэвхтэй арилжаачдын №1 үнэлгээтэй
- Шилдэг хувьцааны арилжааны платформ
- Шилдэг утсанд суурилсан арилжааны платформ


ҮНЭТ ЦААСНЫ ДАНС ХЭРХЭН НЭЭЛГЭХ ВЭ?

1. ОНЛАЙН ВЕБ САЙТ-ЫН ХОЛБООСООР ДАМЖИН ДАНСАА НЭЭЛГЭХ

Монгол Улсын иргэн бүр /насанд хүрсэн, хүрээгүй/ нээлгэх боломжтой.

Данс нээх алхам

- Данс нээх хэсэгт өөрийн мэдээллүүдээ үнэн зөв бүрэн бөглөнө;
- Иргэний үнэмлэхний урд болон ард талын зургийг илгээнэ;
- Иргэний үнэмлэхээ барьж авахуулсан сальфи зургаа оруулна;
- Данс нээх хураамжаа төлж, баталгаажуулна;
- Данс 1-2 хоногт багтан нээгддэг.



И-мэйл _____
 Нууц үг _____
Нэрчүүг сонгох

Нэвтрэх

Брокер: А. Гэрэлмаа
 Утас: 8905-7820
 И-мэйл: gerelmaa@golomtcapital.com

Данс нээх
 Бүртгүүлэх

Жич: Мэдээлэл дутуу эсвэл буруу бөглөгдсөнөөр данс нээгдэхгүй байх эсвэл онлайн вэб ашиглах боломжгүй болдог.


ВЭБСАЙТ (www.egolomt.mn) -ААР ДАНС НЭЭХ

Монгол Улсын насанд хүрсэн иргэн бүр нээлгэх боломжтой бөгөөд та **www.egolomt.mn** вэбсайтаар дамжуулан 2 минутад багтаан үнэт цаасны данс нээх боломжтой.

Данс нээх алхам


- Өөрийн Голомт банкин дахь данс руу www.egolomt.mn – ээр дамжиж нэвтрэх;
- Данс нээхэд шаардлагатай мэдээллийг бөглөх;
 - Хөрөнгө оруулах боломжтой дүн
 - Мэдээлэл хүлээн авах и-мэйл хаяг
 - Хөрөнгө оруулсан туршлага
 - Та АНУ-ын ногоон картын эзэмшигч мөн эсэх (тийм бол сонгох)
 - Та болон таны ойр дотны хүн улс төрд нөлөө бүхий этгээд мөн үү? (тийм бол сонгох)
- ҮЦ данс үүсгэх товчийг дарах.

Жич: Мэдээллээ дутуу бөглөсөн тохиолдолд данс автоматаар нээгдэх боломжгүйг анхаарна уу



2. GOLOMT CAPITAL АППЛИКЭЙШНЭЭР ДАНСАА НЭЭХ ЗААВАР

- Golomt Capital аппликэйшнийг суулгана
- Бүртгэл үүсгэх цэсээр регистрийн дугаар, и-мэйл хаягийг бүртгүүлж, нууц үгийг үүсгэнэ.
- Данс нээх гэрээтэй танилцаж, баталгаажуулна.
- Бүртгэлтэй и-мэйл хаягт ирсэн баталгаажуулах холбоосыг дарж Онлайн арилжааны системд холбогдоно.
- Данс нээлгэхэд шаардагдах үлдсэн мэдээллийг бөглөж дансны хураамж төлөх алхмыг хийснээр данс нээгдэж анхдагч /IPO/ болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцоно.



3. SOCIALPAY АППЛИКЕЙШНЭЭР ДАНСАА НЭЭХ

Монгол Улсын насанд хүрсэн иргэн бүр нээлгэх боломжтой.



Данс нээх алхам

1. Гар утсандаа SocialPay аппликейшн суулгана
2. SocialPay аппликейшнийн дээд талын нэмэлт хэсэгт дээр дарна
3. IPO хувьцаа арилжаа хэсэг рүү орно
4. Өөрийн мэдээллээ үнэн зөв бөглөнө
5. Иргэний үнэмлэхний мэдээллээ бөглөнө
6. Данс нээх хураамжаа төлж баталгаажуулна
7. Таны данс 1-2 хоногт нээгдэнэ.

Жич: Мэдээллээ дутуу бөглөсөн тохиолдолд данс автоматаар нээгдэх боломжгүйг анхаарна уу.



Social Pay аппликейшн татах



АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Голомт Капитал ҮЦК ХХК нь компаниудад үнэт цаас гаргаж хувьцааны санхүүжилт босгох, бондын бүтээгдэхүүнээр дамжуулан өрийн санхүүжилт татах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлэхэд тусладаг андеррайтерийн үйлчилгээг амжилттай үзүүлж байна.

Бид хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагч тус бүрийн эрх ашигт нийцсэн шийдлийг олох зарчмыг баримталдаг.

Андеррайтерийн үйлчилгээний цар хүрээ:

- Олон нийтэд анх удаа үнэт цаас санал болгох (IPO)
- Үнэт цаас нэмж гаргах (FPO)
- Хаалттай болон нээлттэй хүрээнд бонд, өрийн хэрэгсэл гаргах
- Компанийн нэгтгэх, өөрчлөн байгуулах, LBO, M&A
- Компанийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

ХУВЬЦААНЫ САНХҮҮЖИЛТ

Голомт Капитал ҮЦК нь Монголын хөрөнгийн зах зээлд сүүлийн 5 жилд хийгдсэн IPO-ийн дүнгийн 40.2 хувийг татан төвлөрүүлж, Монголын Хөрөнгийн Биржийн түүхэн хугацааны нийт IPO татан төвлөрүүлсэн дүнгээр 1-т бичигдэж байна.

Сүүлийн 5 жилд 13 IPO хийгдэж, ₮136 тэрбумыг босгожээ

Андеррайтер	Нийт IPO эзлэх %*	IPO босгосон дүн	IPO хийсэн компани
Голомт капитал	40.2%	₮54.8 тэрбум	
БиДиСек	9.6%	₮13.1 тэрбум	
Эм Ай Си Си	23.3%	₮31.8 тэрбум	
ТиДиБи Капитал	13.7%	₮18.6 тэрбум	
Өлзий & Ко Капитал	3.8%	₮5.3 тэрбум	
Бумбат Алтай	4.7%	₮6.4 тэрбум	
Мире Эссет Секьюритис	3.7%	₮5 тэрбум	
Стандарт Инвестмент	0.9%	₮1.3 тэрбум	

*Сүүлийн 5 жилийн
Source: Монголын Хөрөнгийн Бирж

LEMON PRESS

Эх сурвалж: Lemon press

Үйлчилгээ:

- Олон нийтэд анх удаа үнэт цаас санал болгох (IPO)
- Үнэт цаасыг хаалттай хүрээнд санал болгох
- Андеррайтерийн үйлчилгээ
- Үнэт цаас нэмж гаргах (FPO)
- Хаалттай болон нээлттэй хүрээнд бонд гаргах

Амжилттай хэрэгжүүлсэн төслүүд					
2018 он	2018 он	2019 он	2019 он	2021 он	
					
Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК-ийн давхар бүртгэлийн (FPO) туслах андеррайтер	Мандал Даатгал ХК-ийн IPO үндсэн андеррайтер	Түмэн Шувуут ХК-ийн IPO үндсэн андеррайтер	Монос Хүнс ХК-ийн IPO үндсэн андеррайтер	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн (CU) IPO андеррайтераар ажилласан зах зээлд тэргүүлэгч компани юм.	

БОНДЫН САНХҮҮЖИЛТ

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2015 оноос хойш нийт 14 компанийн хаалттай болон нээлттэй бондын андеррайтераар ажиллаж, 2021 оны байдлаар нийт 54.4 орчим тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

Бондын андеррайтерийн үйлчилгээний хүрээнд дараах санхүүжилтын төрлүүдийг компаниудад санал болгож байна:

- Компанийн нээлттэй бонд
- Биржийн бус зах зээлийн бонд
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ M&A

Үйлчилгээ:


- Нэгтгэх
- Нийлэх
- Хуваах
- Тусгаарлах
- Хэлбэрийг нь өөрчлөх
- Хамтарсан компани
- Divestitures
- Spinoff
- Sell off
- LBO

Амжилттай хэрэгжүүлсэн компанийн бондууд

<p>2022 он</p>  <p>ГЭРЭГЭ -ГЭРЭГЭ бонд- 2,414,000,000</p>	<p>2021 он</p>  <p>БЭРС ФИНАНС БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА -Бэрс бонд 1- 5,800,000,000</p>	<p>2021 он</p>  <p>CENTRAL ASIAN ROAD INTERNATIONAL FREIGHT FORWARDERS -ТАЗ бонд- 4,000,000,000</p>	<p>2022 он</p>  <p>БЭРС ФИНАНС БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА -Бэрс бонд 2- 4,200,000,000</p>
<p>2021 он</p>  <p>numur Банк бус санхүүгийн байгууллага -Нөмөр бонд- 2,000,000,000</p>	<p>2021 он</p>  <p>МОНКОН КОНСТРАКШН -Монкон Бонд- 15,000,000,000</p>	<p>2020 он</p>  <p>numur Банк бус санхүүгийн байгууллага -Нөмөр Бонд- 1,000,000,000</p>	<p>2020</p>  <p>Master group -Мастер Бонд- 3,800,000,000</p>
<p>2019 он</p> <p>Тий Эй Эн Ресайклинг ХХК -Тий Жэй Эн Ресайклинг бонд- 120,000,000</p>	<p>2019 он</p> <p>Би Жи Эл Прогресс ХХК 2,000,000,000</p>	<p>2019 он</p> <p>Эко Плант Трейд ХХК -Ногоон бонд- 279,000,000</p>	<p>2018 он</p>  <p>АЛТАН НАМАР ТРЕЙД ХХК -Алтан намар бонд- 400,000,000</p>
<p>2018 он</p>  <p>NET CAPITAL financial group -Нэт бонд- 1,000,000,000</p>	<p>2018 он</p>  <p>-Урбан бонд 2- 1,000,000,000</p>	<p>2018 он</p>  <p>БЭРС Капитал Хөгжлийн нүүдэл -Бэрс бонд- 900,000,000</p>	<p>2017 он</p>  <p>МОНГОЛ УЛСЫН УУГАН ҮЙЛДВЭР -Сүү бонд- 6,000,000,000</p>
<p>2017 он</p>  <p>-Урбан бонд 1- 1,065,000,000</p>	<p>2017 он</p>  <p>ERCHIM ENGINEERING LLC -Эрчим бонд- 500,000,000</p>	<p>2017 он</p>  <p>Mongolian mortgage fund -ММФ бонд 2- 750,000,000</p>	<p>2015 он</p>  <p>Mongolian mortgage fund -ММФ бонд 1- 400,000,000</p>

Нийгмийн хариуцлагын хүрээнд:

- Голомт Капитал компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд Нисэхийн эцэст байрлах Хүүхэд хөгжлийн төвд хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, сурч мэдэх үйлсэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор төгөлдөр хуурууд бэлэглэв.
- Оюутанлаг залуусыг дэмжих, төгсөөд ажлын байртай болоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ирээдүй” дадлагажих хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Дэлхий нийтийг цочроосон Ковид 19 цар тахлын үед харилцагчдынхаа эрүүл мэндийг сахин хамгаалах, дархлааг нь дэмжих зорилгоор Монос Хүнс ХК-тай хамтран “Топ фэнүүдээ дархлаажуулъя” “Хөрөнгө оруулагч хүүхдүүдээ дархлаажуулъя” “Ахмад хөрөнгө оруулагчдаа дархлаажуулъя” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн юм.



GCC АКАДЕМИ

Монголын хөрөнгийн зах зээлд шинэ соёлыг түгээхээр зорин ажилладаг Голомт Капитал ҮЦК ХХК-ийн хамт олон хөрөнгийн зах зээлийн талаарх цогц мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор GCC академийг үүсгэн байгуулаад байна.

GCC нь Golomt Capital Coach гэсэн үгний эхний үсгүүдийн товчлол бөгөөд хүссэн хүн бүрт хөрөнгийн зах зээлийн талаарх суурь мэдлэгийг олгож, шилдэг хөрөнгө оруулагчдыг бэлтгэх, хөгжүүлэх, дасгалжуулах замаар монголын төдийгүй дэлхийн хөрөнгийн зах зээлээс өндөр өгөөж хүртэх боломжийг нээх зорилготой юм.

Тус академийн сургагч багш нар нь Голомт Капитал ҮЦК ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа болох брокер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг дотоод гадаадын харилцагч түншүүддээ үзүүлж ирсэн, олон жилийн дадлага туршлагатай, өндөр мэдлэг боловсролтой, салбартаа үнэлэгдсэн мэргэжлийн баг хамт олон юм. Мөн монголын төдийгүй дэлхийн эдийн засаг, салбарын зах зээлийн судалгааг тогтмол амжилттай гүйцэтгэж ирснээрээ давуу талтай билээ.

GCC академи нь анхан, дунд, ахисан гэсэн 3 түвшний сургалтыг байгууллага, хувь хүний захиалгаар танхимын болон онлайн байдлаар зохион байгуулж буйгаараа онцлогтой юм.

2021 онд харилцагчийн хөрөнгийн зах зээлийн боловсролыг дэмжих зорилтын хүрээнд хөрөнгийн зах зээлийн талаарх нийт 500 орчим контент бэлтгэсэн бөгөөд харилцагчдад зориулсан 2 удаагийн сургалтыг онлайнаар зохион байгуулж, 400 орчим хүн хамрагдав.

Мөн харилцагчдад зориулсан гадаад арилжааны сургалтыг зохион байгуулж, түүнд үндэслэн “Interactive Brokers” демо арилжааны уралдааныг хийсэн.





Даваа гараг бүрд:

“MARKET IMPULSE” LIVE

Өнгөрсөн 7 хоногт дэлхийд болон монголын эдийн засаг, хөрөнгийн зах зээлд өрнөсөн голлох үйл явдал, мэдээлэл, ирэх 7 хоногт өрнөх үйл явдлыг тоймлодог.



Мягмар гараг бүрд:

“ХАРИЛЦАГЧИЙН ЦАГ” LIVE

Харилцагчдаас ирдэг түгээмэл асуултад хариулт өгөх замаар харилцагчийн боловсролыг дэмжих, бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах зорилгоор бэлтгэн хүргэж байна.



Лхагва гараг бүрд:

“THE HIGHER HIGH” LIVE

/Онцлох хувьцааны техник шинжилгээ/

Онцлох компанийн хувьцаа, хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн, салбарын техник шинжилгээг хийж танилцуулах замаар харилцагчийн хөрөнгө оруулалтын шийдвэрт туслаж байна.



Пүрэв гараг бүрд:

“MACRO VOICE” LIVE

Монголын хөрөнгийн зах зээлийн онцлох үйл явдал, бүтээгдэхүүн, хувьцаат компаниудын талаарх мэдээллийг хүргэдэг.



Баасан гараг бүрд:

“ХУВЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ” LIVE

Тус лайваар дамжуулан дэлхийн хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломж бүхий хувьцаа, салбаруудын талаарх шинжилгээг танилцуулдаг.


Bluebook товхимол

Голомт Капитал компани нь Монгол Улсад анх удаа дэлхийн хөрөнгө оруулалтын сан, үнэт цаасны компаниудын адилаар эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээ, ирэх жилүүдийн чиг хандлагыг тодорхойлсон BLUEBOOK товхимлын 2 дугаарыг бэлтгэж, хэвлэмэл болон онлайн хувилбараар харилцагчдад хүргэсэн билээ. Цаашид хагас жилд нэг удаа бэлтгэхээр зорин ажиллаж байна.



Зах зээлийн тойм болон онцлох компанийн судалгаа

Олон улсын болон дотоодын эдийн засаг, хөрөнгийн зах зээл, таваарын зах зээл, валютын зах зээлийн тойм, онцлох компанийн судалгааг долоо хоног, сар улирлаар тогтмол бэлтгэж, цахим сувгууд болон харилцагчдын бүртгэлтэй и-мэйл хаягаар илгээж байна.



Харилцагчийн хөтөч гарын авлага



Голомт Капитал ҮЦК ХХК нь ухаалаг хөрөнгө оруулагчдыг бэлтгэх, дэмжих зорилгоор **trader.golomtcapital.com**

онлайн арилжааны систем болон Golomt Capital, SocialPay аппликэйшнийг хэрхэн ашиглах, хөрөнгийн зах зээлтэй холбоотой бүхий л мэдээллийг багтаасан гарын авлагыг бэлтгэн түгээгээд байна.

Мөн харилцагч та "Golomt capital" youtube сувгаас trader.golomtcapital.

com, Golomt Capital, SocialPay аппликэйшнээр данс нээх, арилжаанд оролцох зааврыг видео хэлбэрээр хүлээн авахаас гадна өдөр тутмын болон тойм судалгааны талаарх LIVE-уудыг үзэх боломжтой юм.





Golomt Capital

+1 (+0.50%) NVDA 231.22USD (-0.89%)



YAMAHA

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



С.Ган-Эрдэнэ
Гүйцэтгэх захирал

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



Г.Золжаргал
Үйл ажиллагаа
хариуцсан захирал



Б.Түвшинбаяр
Нягтлан бодогч

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭС



Б.Тэлмэн
Шинжээч
☎ 9585-2121



Р.Дарханбаяр
Шинжээч
☎ 9490-4321



Б.Буяннэмэх
Шинжээч
☎ 8909-2808

ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС



Т.Азтүшиг
Ахлах шинжээч
☎ 8604-2772



М.Чинсанаа
Шинжээч
☎ 8818-1888



А.Билгүүн
Техник шинжээч
☎ 8806-7847

АРИЛЖААНЫ ХЭЛТЭС



Н.Данзандагва
Арилжааны хэлтсийн
захирал
☎ 8610-5050



Н.Гомбодорж
Ахлах брокер
☎ 8888-0272



С.Цогтхүү
Гадаад арилжааны
брокер
☎ 8610-3636



Б.Лхамсүрэн
Номинал данс хариуцсан
ажилтан
☎ 8005-88022



Э.Намуунаа
Брокер
☎ 8083-6622



Н.Дөлгөөн
Брокер
☎ 8003-7272



Ж.Мөнхзаяа
Брокер
☎ 8004-3838



Э.Намуунаа
Брокер
☎ 8083-6622



Н.Дөлгөөн
Брокер
☎ 8003-7272

МАРКЕТИНГИЙН ХЭЛТЭС



Д.Бямбатогоо
Маркетинг
хариуцсан захирал



Ц.Энхжаргал
Дизайнер



Ц.Галбадрах
IT инженер

Дотоод арилжааны брокер:
Монголын Хөрөнгийн Бирж
(+976) 7012-1530
(+976) 8003-7272
(+976) 8083-7744

Гадаад арилжааны брокер:
АНУ, Канад, Англи, Бусад бирж
(+976) 8006-9977
Хонгконгийн бирж
(+976) 8610-3636

Санхүүжилт татах:
(+976) 9490-4321
(+976) 9585-2121